



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

СТАТИСТИКИЙН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН СҮМ ХИЙД, ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН 2014 ОНЫ ТООЛЛОГЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот



НИЙСЛЭЛИЙН СҮМ ХИЙД, ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН 2014 ОНЫ ТООЛЛОГЫН ТАЙЛАН

НЭГ. ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хууль, эрх зүйн үндэслэл

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Нийслэлийн Статистикийн газрын даргын хамтран баталсан 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт албан ёсны зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, шашны байгууллагын тооллого явуулж, бүртгэлжүүлэх, сүм хийдийн байршлыг тогтоож, орон зайн мэдээлэл бүхий цахим сан үүсгэх ажил хийгдэв.

Сүм хийд, шашны байгууллагыг бүртгэлжүүлэх тооллогыг дараах хууль тогтоомж, эрх зүйн актыг үндэслэн зохион байгуулав. Тухайлбал:

- Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 8 дах заалт
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дах заалт
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 74 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”

Тооллогын зорилго, ач холбогдол

Тооллогын үндсэн зорилго нь нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдийн талаар дэлгэрэнгүй түвшинд судалж, бүртгэлжүүлэх, байршлыг тогтоож, мэдээллийг газрын зурагт оруулах, олон улсын стандартад нийцсэн, харьцуулахуйц тоон үзүүлэлт, мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлж, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, сүм хийдтэй харилцах харилцаа, бодлого боловсруулахад шаардагдах тоон мэдээллийг бий болгоход чиглэгдсэн.

Тооллогыг явуулснаар дараах үр дүнд хүрэв. Тухайлбал:

- Сүм хийд, шашны байгууллагын 2014 оны тооллого нь Монгол Улсад анх удаа зохион байгуулагдаж, орон зайн байршлаар үүсгэсэн мэдээллийн сан бүхий тооллого болсноороо чухал ач холбогдолтой юм.
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн нууцлалд нийцүүлэн тооллогын мэдээллийн сан, орон зайн мэдээллийн санд нэвтрэх эрхийг нууцын баталгааны хамт баталгаа гаргасан ажилтан, НИТХ-ын дэргэдэх Шашин, сүм хийдийн асуудал эрхэлсэн ажлын хэсэг, НИТХ-ын Ажлын албанд хүлээлгэн өгөх бөгөөд ингэснээр шашин, сүм хийдийн талаарх мэдээллийг НИТХ-ын Тэргүүлэгчид, нийслэлийн удирдлагууд, нутгийн захиргааны холбогдох байгууллагууд ашиглах бүрэн боломжтой.

- Энэ удаагийн тооллогоор шашны үйл ажиллагаа явуулж буй албан ёсны зөвшөөрөлтэй төдийгүй зөвшөөрөлгүй нийт сүм хийдийг тоолов.
- Нийслэлийн нутаг дэвсгэрт ажиллаж байсан болон ажиллаж байгаа нийт сүм хийдийн шашны төрөл, урсгал чиглэл, байршил, үйл ажиллагааны байдлын талаарх анхан шатны бүртгэл эрс сайжирч, бодит байдалд нийцэв.
- Нийт сүм хийд, шашны байгууллагын тоон болон орон зайн дэлгэрэнгүй мэдээллийн санг бүрдүүлж, цаашид сүм хийд шинээр бүртгэх, зөвшөөрлийн хугацааг сунгах, хаяг байршилд өөрчлөлт оруулах зэрэг бусад баяжилтыг тухай бүр хийх боломжтой болгов.
- Тооллогод нийслэлийн нийт нутаг дэвсгэр, нийт сүм хийдийг бүхэлд нь хамруулснаар шашны байгууллагуудын байршил, үндсэн үйл ажиллагааны байдалд дүн шинжилгээ хийх, шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг хянах зэрэг ажлын чиглэлүүдийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг сайжруулсан.
- Сүм хийдтэй харилцах харилцаа, бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлгээ өгөх зэрэгт шаардлагатай мэдээллийг бий болгов.

Тооллогын удирдлага, зохицуулалт

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Нийслэлийн Статистикийн газрын даргын хамтран баталсан 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу тооллогыг зохион байгуулах НИЙСЛЭЛИЙН КОМИСС-ыг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Нийслэл хотод сүм хийдийн тооллогыг зохион байгуулах комиссын ахлагчаар Нийслэлийн Статистикийн газрын мэргэжилтэн Н.Байгалмаа, гишүүдээр дүүргүүдийн Статистикийн хэлтсийн шашин, сүм хийдийн мэдээлэл хариуцсан дараах 8 ажилтан ажиллав. Үүнд:

- Багануур дүүргийн Статистикийн Хэлтсийн дарга Д.Жаргалмаа
- Баянгол дүүргийн Статистикийн Хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Нандинцэцэг
- Баянзүрх дүүргийн Статистикийн Хэлтсийн мэргэжилтэн Б.Ган-Эрдэнэ
- Налайх дүүргийн Статистикийн Хэлтсийн мэргэжилтэн Х.Алтанцэцэг
- Сонгинохайрхан дүүргийн Статистикийн Хэлтсийн мэргэжилтэн Э.Цэнд-Аюуш
- Сүхбаатар дүүргийн Статистикийн Хэлтсийн мэргэжилтэн А.Баярсүрэн
- Хан-Уул дүүргийн Статистикийн Хэлтсийн мэргэжилтэн А.Ербахыт
- Чингэлтэй дүүргийн Статистикийн Хэлтсийн мэргэжилтэн Д.Баярцэцэг

Статистикийн газар нь тооллогын ажлыг дагнан хариуцаж, Монгол Улсын “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хууль хэрэгжиж эхэлсэн 1994 оноос хойш 2014 оныг дуусталх 20 жилийн хугацаанд НИТХ-аас шашны байгууллагын асуудлаар гаргасан тогтоол шийдвэрийг цуглуулан судлав. Үүний зэрэгцээ нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байсан, одоо явуулж буй зөвшөөрөлтэй нийт 286 сүм хийдийн дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох бүртгэл, мэдээллээс тодруулан бүрдүүлэв. Түүнчлэн нийт сүм хийдийн бүртгэл, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг судлан тооллогын асуулгыг боловсруулах, тооллогын ажилтныг бэлтгэх, тоолох, тооллогын мэдээллийг цуглуулж, боловсруулан тооллогын тайланг гаргав.

Нийслэл, дүүргийн статистикийн албад нь сүм хийд нэг бүрийг тооллогод бүрэн хамруулах нөхцлийг бүрдүүлж, зохицуулах үүргийг хариуцах, тооллогын бэлтгэл ажилд шаардлагатай бүртгэл, мэдээллийг нутаг дэвсгэр, тоолох нэгж бүрээр дэлгэрэнгүй гаргах, тооллогын асуулга, зааварт мэргэжлийн зөвлөмж өгөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тооллогын дүн мэдээллийг үндэслэн сүм хийдийн мэдээллийн санг байгуулах ажил үүргийн хуваарьтай ажиллав.

Тооллогыг илүү үр дүнтэй, олон улсын аргачлал, стандартад нийцэхүйц байлгах үүднээс тооллогын удирдамж, төлөвлөгөө, асуулга, түүнийг нөхөх заавар, зохион байгуулалтын бусад асуудлаар харилцан санал солилцож ажилласан.

Мөн Иргэний Харьяалал, Шилжилт Хөдөлгөөний Ерөнхий газарт хүсэлт тавьж, тус газрын Зөвшөөрөл, бүртгэлийн газрын ажилтан Г.Ганзаяаг тооллогын ажилтнуудын сургалтад урьж оролцуулан, мэргэжлийн заавар, зөвлөмж авч, нэмэлт мэдээлэл хийлгэв. Улмаар тооллогын явцад тус газрын дэмжлэгтэйгээр шашны байгууллагын тэргүүнээр ажилладаг гадаадын иргэдийн мэдээллийг тодруулж, мөн Нийслэлийн Архивын газарт албан бичгээр хандаж, зарим сүм хийдийн дутуу бүрдсэн мэдээлэлд лавлагаа авч ажиллав.

Тооллогын бэлтгэл ажил

Сүм хийдийн тооллогын бэлтгэлийг дараах байдлаар хангав. Тухайлбал:

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагад бүртгэлтэй буюу нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй сүм хийдийн 1994-2014 оны мэдээлэлд тулгуурлан тооллогод хамрагдах жагсаалтыг сүм хийдийн байршил, дүүрэг, хороогоор гаргаж, тооллогч нарт лавлагаа болгож өгсөн.
2. Сүм хийдийн тооллогын асуулгын хуудасны загварыг хийж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Иргэний Харьяалал, Шилжилт Хөдөлгөөний Ерөнхий газар зэрэг холбогдох байгууллага, ажилтны саналыг авч тусган, нөхөх зааврын хамт боловсруулав.
3. Тооллогын бүх үе шатыг хамруулсан нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан батлуулж, ажиллав.
4. Тоологч нарыг сонгон шалгаруулж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.
5. Тооллогын асуулгын хуудас, нөхөх заавар, GPS ашиглах заавар гэх мэт тооллогын ажилтанд шаардлагатай гарын авлага, сургалтын болон сурталчилгааны материал зэргийг тоолох товоос өмнө хэвлүүлж, бэлэн болгосон.
6. Тооллогод хамрагдсан сүм хийд, шашны байгууллагад олгох тооллогын гэрчилгээг өнгөтөөр хэвлүүлсэн.
7. Тооллогын мэдээллийг боловсруулах програм хангамжийн бодлогын даалгаврыг боловсруулж, мэдээлэл боловсруулалтын үе шат бүрийг автоматжуулах боломжийг бүрдүүлэв.
8. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Нийслэлийн Статистикийн газрын даргын хамтран баталсан 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн "Ажил гүйцэтгэх гэрээ"-гээр сүм хийдийн тооллогыг явуулахад шаардагдах 17.8 сая төгрөгийг батлуулж, батлагдсан төсвийн дагуу зарцуулав. Тооллогын төсвийн зардлын тооцоог урьдчилан хийж, аль болох хэмнэлт гаргаж, бага зардлаар хийхэд анхаарч, дараах хэмнэлтийг гаргасан. Үүнд:
 - ✓ Тооллогод ашигласан GPS төхөөрөмжийг худалдаж авалгүйгээр бусад шаардлагатай төхөөрөмжийн хамт Нийслэлийн Статистикийн газар болон Үндэсний Статистикийн хорооноос үнэ төлбөргүй түр хугацаагаар зээлж ашиглах, гар утасны GPS ашиглах зэргээр зардлыг хэмнэв.

- ✓ Тооллогын мэдээлэл боловсруулах програм хангамжийг зах зээлийн үнээс доогуур буюу аль болох судалгааны бэлэн програмыг ашиглахаар тооцсон.
 - ✓ Тээврийн зардлыг зах зээлийн дундаж үнээс доогуур тогтоов.
 - ✓ Тоолох хугацаа 25-30 хоног боловч өдөрт тоолох сүм хийдийн тоог 3-5 байхаар тогтоож, тоолох өдрийг 15 өдөр болгон багасгасан. Ингэснээр тоологч нарт олгох хоол, унаа, утасны зардлыг хэмнэв.
 - ✓ Тоологчийн ажлын урамшууллыг тоолсон сүм хийдийн тоо, тооллогын асуулгын хуудсыг бүрэн гүйцэт нөхсөн байдал зэргээр ажлын чанар, хугацаа, мэдээллийн алдаагүй байдлыг харгалзан олгосон. Өөрөөр хэлбэл, “зааврын дагуу хэн их сүм хийдийг тоолно, түүнд илүү урамшуулал” гэсэн зарчмыг баримтлав.
 - ✓ Тооллогын явцад болон мэдээлэлд хийх мониторингийн замын чиглэлийг зөвхөн сүм хийд олноор байршсан, захын гэр хороололд, анхан шатны бүртгэлийн мэдээлэл зөрүүтэй чиглэлд явахаар тооцож, тээврийн зардлыг хэмнэв.
9. Тооллогын ажилтнууд тоологч, мэдээллийг шалгагч, шивэгч нарт сургалт явуулах сургагч багшийг Нийслэлийн Статистикийн газраас урьдчилан бэлтгэж, сургалтыг чанартай зохион байгуулсан нь тооллогын үр дүнд эерэгээр нөлөөлсөн.

Тооллого явуулсан хугацаа, хамрах хүрээ, арга зүй

Тооллогыг 2014 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 5-ны өдрийг дуустал 21 хоногийн хугацаанд явууллаа.

Тооллогын явцын талаарх мэдээллийг 15 тоологч бүрээс өдөр тутамд авч, урьдчилан гаргасан жагсаалттай тулган бүртгэж, тоолсон сүм хийдийн тоо мэдээг зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй гэсэн ангиллаар гаргаж, зарим шаардлагатай зохицуулалтыг шуурхай хийж байв. Тооллогын өдрүүдэд Нийслэлийн Статистикийн газрын тооллого хариуцсан ажилтан өдөр бүр 8-19 цагийн хооронд жижүүрлэн ажиллаж, телефон утсаар лавласан асуулт болон үүссэн нөхцөл байдал, асуудалд тухай бүр хариулт өгөх, зохицуулах зэргээр шийдвэрлэсэн.

Тооллогын маягтад тусгагдсан асуултууд 2014 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 5-ны өдрийг дуустал хугацаагаар буюу тооллогын товын байдлаар нөхөх зарчмыг баримталсан.

Тооллогод нийслэлийн нутаг дэвсгэрт Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор олгосон шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй ажиллаж байгаа нийт сүм хийдийг хамруулав.

Сүм хийд, шашны байгууллага бүр дээр биечлэн очиж, мэдээлэл нь нийтлэг, иж бүрэн байх нөхцлийг хангах зорилгоор тооллогын батлагдсан маягтын үзүүлэлт нэг бүрийг зааврын дагуу нөхөж бичих аргаар мэдээллийг цуглуулсан.

Мөн сүм хийдийг бүртгэлжүүлэх энэхүү тооллогод GPS төхөөрөмж ашиглан сүм хийд нэг бүрийн байршлыг тогтоов.

Тооллогын үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, аргачлал

Тооллогын асуулгын хуудсыг боловсруулахдаа НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 74 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ыг баримталж, сүм хийдийн тухай ойлголт, бүртгэлийн үзүүлэлтүүд, “Сүм хийдийн үйл ажиллагаа”-ны CX-1 маягтыг үндэслэв.

Энэ удаагийн тооллогын асуулгын хуудас, үзүүлэлтүүдийн тодорхойлолт, асуулгын хуудсыг нөхөх зааврын төслийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, асуудал хариуцсан ажилтанд урьдчилан танилцуулж, албан ёсны зөвшөөрлийг авсан.

Тооллогод “Засаг захиргааны ангилал”, “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангилал” (ISIC-4.0), Монгол Улсын бүсчлэлийн код (аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны код) зэргийг нэгдсэн журмаар мөрдөж ажилласан.

Сүм хийдийн ойлголт	Тодорхойлолт
Шашны байгууллага	Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг шашны байгууллага гэнэ ¹ .
Албан ёсны зөвшөөрөлтэй сүм хийд	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 74 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ын дагуу зөвшөөрөл олгогдсон сүм хийд.
Байршил	Нийслэлийн ИТХ-ын тогтоолоор олгогдсон зөвшөөрөлд заагдсан нутаг дэвсгэр буюу шашны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй барилга, байр сууц, талбайн байрлаж байгаа газрын хаяг.

Тооллогын чанарын шалгалт

Тооллогын явц, хамралт, асуулгын хариултын үнэн зөв, бодит байдлыг хянах зорилгоор нийслэлийн тооллогын комиссын ахлагч хяналт шалгалт хийж ажиллав. Тоологч нарын ажлын явцтай өдөр тутамд танилцаж, лавлагаа болгож өгсөн жагсаалтад буй сүм хийдийг тооллогод бүрэн хамруулсан эсэх, тухайн хорооны нутаг дэвсгэрт байгаа бүх сүм хийдийг тоолсон эсэх, тооллогын асуулгыг аль болох бүрэн нөхөх, GPS-ийг ашиглаж сүм хийдийн байршлыг зөв тогтоосон эсэхийг тогтмол хянаж, тооллогын асуулгын хариултыг бусад мэдээлэл, бүртгэлтэй уялдуулахад гол анхаарлаа хандуулсан.

Тооллогын хамралт ямар түвшинд болсныг тухайн хорооны Засаг даргаар үнэлүүлж, батламж, тодорхойлолт авсан бөгөөд асуулгын дутуу мэдээллийг Нийслэлийн Архивын газрын сан хөмрөгт хадгалагдаж буй шашны байгууллагын талаарх материал, Нийслэлийн Улсын Бүртгэлийн газар, Иргэний Харъяалал, Шилжилт Хөдөлгөөний Ерөнхий газрын Зөвшөөрөл, бүртгэлийн газрын мэдээллийн сан зэрэг холбогдох ажлын албад, ажилтантай хамтран нөхөх зэргээр нэлээд хүчин чармайлт гарган ажиллав. Тухайлбал:

- Баянгол дүүрэгт байрлах Долма лхахан сүм, түүний тэргүүн Чанцалдуламын талаарх мэдээлэл олдохгүй, тооллогын ажилтныг ихээхэн төөрөгдүүлж байв. Архивт хадгалагдсан мэдээллээс тус сүмийн тэргүүний жинхэнэ нэр Гүнсэн овогтой Наранцэцэг болохыг, өмнө нь НИТХ-ын Тэргүүлэгчдийн хэд хэдэн удаагийн тогтоолд тэмдэглүүлсэн Чанцалдулам хэмээх нэр түүний “сахилын нэр” байсныг олж тогтоосон.
- Баянзүрх дүүргийн нэг сүмийн нэрийг англи болон крилл үсгээр (VWAM Mongolia төв, Вай Ви Эм) хоёр янзаар бичиж НИТХ-ын тогтоолд оруулсан нь хоёр өөр сүм мэтээр ойлгогдож, жагсаалтад бүртгэгдсэн байсан нь тооллогын явцад илэрсэн.
- Хан-Уул дүүргийн “Амьд ус” цуглааны нэр солигдож, “Амийн өргөө” цуглаан, мөн Сонгинохайрхан дүүргийн “Жанчив ишдашлүндүвлин” хийд нэрээ сольж, “Үржинбадмаалин” хийд болсон тул өөрчлөгдсөн “шинэ” нэр бүрээр тоологдсон. Дээрх хоёр сүм хийдийн зүгээс нэр солиулах асуудлаар НИТХ-д хандаж, хүсэлт гаргасан эсэх, хэрэв хандсан тохиолдолд тогтоол гаргаж, нэр солигдсон болохыг гэрчилж, албажуулсан эсэх нь тодорхойгүй байв.

¹ Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйл

Зөвшөөрөл олгох, хугацааг сунгах талаар гаргасан НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, түүний хавсралтыг хуурамчаар үйлдсэн зөрчил христийн шашны зарим нэг сүмд мөн илрэв. Тухайлбал:

- Баянзүрх дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Сайн үйлс сүм нь НИТХ-ын Тэргүүлэгчдийн 1999 оны 118-р тогтоолоор "зөвшөөрөл авсан" хэмээн мэдээлж, хуулбар үнэн болохыг гэрчилж, баталгаажуулсан баримт, тус баримтад 2014 оны 11-р сарын 25-ны өдөр УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын хуулбар үнэн тамга дарж, Ц.Цолмон гарын үсэг зурсан тогтоолын хуулбарыг тооллогын ажилтанд үзүүлсэн байв. Хуулбарыг 1999 оны 118 тоот тогтоолын эх хувьтай тулгаж нягтлахад "Сайн үйлс сүм"-д зөвшөөрөл олгосон тухай огт дурдаагүй, шашны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоогүй байв.
- Тус сүм нь "огт олгогдоогүй" зөвшөөрлийн хугацааг 2000 оноос хойш 12 удаа сунгуулсаны дотор 2004 оны 26-р тогтоолоор гурван жилээр, хамгийн сүүлд НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 82-р тогтоолоор нэг жилээр "сунгуулсан" байна. Сүмийн Удирдах зөвлөлийн даргаар Япон Улсын иргэн Шимакура Такаши ажилладаг бөгөөд анх 1999 онд Ж.Энхтуяа гэдэг хүн зөвшөөрөл авч байсан гэсэн тайлбар өгсөн.
- Ийм төрлийн өөр нэг зөрчил Хан-Уул дүүрэгт байрлах "Гэгээн эх Мариа" сүмд гарав. Тус сүмд НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 48-р тогтоолоор зөвшөөрөл олгосон хэмээх мэдээлэл худал байв. Сүмийн ажилтнуудад байсан хуулбарыг эх тогтоолтой тулгаж үзэхэд тогтоолын хавсралтад байгаа жагсаалтын хамгийн сүүлд бичигдсэн "өөр сүмийн нэрийг дарж" оронд нь Гэгээн эх Мариа сүм хэмээн бичиж оруулсан байв. Тус сүм нь зөвшөөрлийн хугацааг 3 удаа сунгуулсан бөгөөд НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 82-р тогтоолоор хамгийн сүүлд сунгасан байна.

Эндээс үзэхэд шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох, хугацаа сунгах талаар гаргасан НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын эх хуулбарыг хувилж, сүм хийд, шашны байгууллагад тараан олгох, баталгаажуулах үйл явцын хяналт сул байдлыг далимдуулан тогтоосон дүрэм, журам зөрчиж, хууль бус үйлдэл хийх явдал гардаг байна.

Бусад мэдээлэл, бүртгэлтэй уялдуулах шалгалтын сацуу тооллогын хуудсын асуулт, үзүүлэлт хоорондын уялдаа, бүх асуулт бүрэн хариулагдсан эсэх, GPS цэгийн давхардал байгаа эсэх, үнэмшилтэй утгын буюу байж болох утгаас давсан онцгой утга байгаа эсэх, статистик анализ дээр тулгуурласан хамаарлын болон логик шалгалт, утгуудын нийлбэр нийт дүнтэй тэнцүү эсэх зэрэг шалгалтуудыг хийж, илэрсэн алдаанд холбогдох засварыг хийсэн.

Мэдээлэл боловсруулах, үр дүнгийн хүснэгт

Сүм хийдийг бүртгэлжүүлэх, байршлыг тогтоох энэхүү анхны тооллогоор газар зүйн мэдээллийн системийн сансарын зургийг ашиглаж, орон зайн мэдээллийн сан үүсгэх зорилт тавьсан нь онцлог, давуу талтай болов.

Тооллогын мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, шалгах, засварлах болон GPS-ийн мэдээллийг боловсруулах, үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулах зэрэг тооллогын бүх үе шаттай холбоотой програм хангамжийн бодлогын даалгаврыг боловсруулж, 5 програмыг боловсруулсан.

- **Тооллогын асуулгын хуудасны шивэлт хийх вэб програм** (хавсралт зураг 1)

Тооллогын асуулгын хуудсыг цахим хэлбэрт шилжүүлэх шивэлтийн вэб програм нь маягтын дагуу асуулт бүрийн хариултыг оруулна. Програм нь давхар цэг, алдаатай өгөгдөл, буруу шивэлтийг хянаж, алдаатай өгөгдөл оруулахгүй, мэдээлэл нэмж, засварлаж, устгадаг байхаар хийгдсэн.

Програмыг Статистикийн газрын вэб сервер дээр байрлуулсан тул интернеттэй орчноос мэдээллийг баяжуулах боломжтой. Програмд хийсэн үйлдэл бүрийг хадгалж, хэн хэзээ ямар өөрчлөлт оруулсныг харж болно.

Мэдээллийн санд өөрчлөлт хийх, баяжуулах тусгай эрхтэй ажилтан зөвхөн компьютераас төдийгүй гар утас болон бусад электрон төхөөрөмжөөс хандаж болно.

- **GPS төхөөрөмжөөс дата бааз руу хөрвүүлэх програм**

Энэ програм нь GPS төхөөрөмжөөс өгөгдлийг хуулж, газрын зурагт харуулах өгөгдлийн сангийн формат руу хөрвүүлдэг програм юм. Програм нь давхардлын цэгийг тогтоож, алдаатай өгөгдлийг илрүүлж чадна. Жишээ нь: Монгол Улсын газар зүйн байрлалаас өөр өгөгдлөөр (өндөр, байршил гэх мэт) оруулж байгаа буруу мэдээллийг илрүүлнэ.

- **Гар утсыг GPS болгон ашиглах, мэдээллийг дата бааз руу хөрвүүлэх програм**

Өнөө үед ашиглаж буй iOS, Android гэсэн үндсэн 2 системийн гар утасны HeadGPS програмыг идэвхижүүлж, энэ удаагийн сүм хийдийн тооллогод гар утсыг GPS төхөөрөмж болгон ашиглав. Гар утсаар тогтоосон GPS өгөгдлийг мэдээллийн сан руу хөрвүүлж, тухайн сүм хийдийг газрын зурагт байршуулах програмыг боловсруулсан. Энэ програм нь давхардлын цэгийг тогтоож, алдаатай өгөгдлийг илрүүлнэ.

- **Газрын зураг дээр тооллогын үр дүнг харуулах програм (хавсралт зураг 2, 3, 4, 5)**

Газрын зурагт тооллогын үр дүнг харуулах програм нь шивэгдсэн мэдээллийг GPS-ын өгөгдөлтэй холбож, Google Map-ыг ашиглан онлайнаар газрын зурагт мэдээллийг харуулна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт тоологдсон нийт сүм хийдийг стандарт (хавсралт зураг 2) болон satellite (Хавсралт зураг 3, 4) буюу хиймэл дагуулаас авсан газрын зураг, hybrid (Хавсралт зураг 5) буюу хосолмол газрын зурагт тус тус байршуулж, уг байршлын цэг дээр дарахад тухайн сүм хийдийн тооллогын асуулгын хариулт, мэдээлэл бүрэн гарна.

- **Үр дүнгийн хүснэгтийг хүссэн үзүүлэлтээр гаргах вэб програм (хавсралт зураг 6)**

Тооллогын үр дүнгийн хүснэгт (Хавсралт зураг 6) гаргах вэб програм нь тооллогын асуулгын дагуу нэн шаардлагатай 16 хүснэгтийг нийслэлийн дүнгээр төдийгүй, дүүрэг, хорооны түвшинд гаргана.

Уг програмд хандах эрхтэй ажилтны хийсэн өөрчлөлт, баяжилтаар үр дүнгийн хүснэгт шууд өөрчлөгдөж байхаар програмыг боловсруулсан.

Үүнээс гадна сүм хийдийн тооллогын мэдээллийн сангаас Access, Excel програм ашиглан хүссэн үр дүнгийн хүснэгт гаргах боломжтой.

Тооллогын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлыг Нийслэлийн Статистикийн газар хариуцан хийв. Цаг үеийн нөхцөл байдал, ялангуяа сүм хийдийн талаарх мэдээллийн хэрэгцээтэй байдлыг харгалзан энэ удаагийн тооллогын үр дүн, тайланг боловсруулав.

Тооллогын үр дүнгийн үзүүлэлтүүдийг албан ёсны болон захиргааны статистикийн холбогдох мэдээлэл, бусад анхан шатны бүртгэлтэй харьцуулан хянаж, эцсийн үр дүнг боловсруулсан.

Тооллогын мэдээлэлд үндэслэсэн үр дүнгийн тайланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллага, түүний Тэргүүлэгчид, нийслэлийн удирдлага, холбогдох байгууллага, хэрэглэгчдэд хэвлэмэл болон цахим хэлбэрээр тархаана.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн нууцлалд нийцүүлэн тооллогын мэдээллийн сан, орон зайн мэдээллийн санд нэвтрэх эрхийг нууцын баталгааны хамт баталгаа гаргасан ажилтан, НИТХ-ын дэргэдэх Шашин, сүм хийдийн асуудал эрхэлсэн ажлын хэсэг, НИТХ-ын Ажлын албанд хүлээлгэн өгнө.

ХОЁР. НИЙСЛЭЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ СҮМ ХИЙД

❖ Сүм хийдэд зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

“Төр, сүм хийдийн харилцааны тухай” хуулийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд хангуулах ажлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм, хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох ажил 1994 оноос хэрэгжиж эхэлсэн.

1993 онд батлагдсан “Төр, сүм хийдийн харилцааны тухай” Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйл, нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм, хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох тухай журмыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гаргаж, зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ирсэн.

Зураг 1. НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор зөвшөөрөл “шинээр” олгогдсон болон “хугацаа сунгагдсан” шашны байгууллагын тоо, 2000-2014 он



Нийслэлийн шашны байгууллагуудын үйл ажиллагаа 2007 оноос нэлээд идэвхжиж эхэлсэн гэж үзэх үндэслэлтэй юм. Учир нь 2005 он хүртэл давхардсан тоогоор нэг жилд дээд тал нь 30 гаруй сүм хийд, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаагаа сунгуулж ажилласан байхад 2010 онд 110 болтлоо огцом өсч, 2012 оны эцэст 138 болж нэмэгдсэн нь өмнөх оныхоос 14.0 хувиар өссөн байна.

2014 онд НИТХ-ын Тэргүүлэгчдийн 6 удаагийн хуралдаанаар нийт 13 шашны байгууллагад шинээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож, 131 шашны байгууллагын өмнө олгосон зөвшөөрлийн хугацааг нэг жилээр сунгах асуудлыг авч хэлэлцэн шийдвэрлэжээ.

Шинээр байгуулагдсан сүм хийдийн тоо сүүлийн 20 жилийн хугацаанд харилцан адилгүй дүнтэй байна. 2004 онд нийслэлд 28 шашны байгууллага шинээр үүсгэн байгуулагдаж байсан бол 2010 онд хамгийн олноор байгуулагдсан тохиолдол гарч, 42 шашны байгууллагад шинээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож байжээ.

Ийнхүү сүүлийн 20 жилийн дотор нийтдээ 286 сүм хийдэд нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа эрхлэн явуулах албан ёсны зөвшөөрөл олгогдож байсны дийлэнх буюу 232 (81.1%) сүм хийд нь 2000-2014 оны хооронд шинээр үүсгэн байгуулагдсан байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдийн талаар мэдээллийн дараах эх үүсвэр байдаг. Үүнд:

- **Сүм хийдийн анхан шатны тоо бүртгэл²**
Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй сүм хийдийг байнга бүртгэж, дэлгэрэнгүй мэдээллийг бүрдүүлдэг.
- **Сүм хийдийн улсын тоо бүртгэл**
Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж улмаар Үндэсний Статистикийн Хорооны Бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаа сүм хийд, шашны байгууллагын жагсаалт, албан ёсны статистикийн мэдээллийн сан.

❖ 2014 оны тооллогод хамрагдсан сүм хийд

Сүм хийд, шашны байгууллагын тооллогын товын үеэр нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 10 шахам шашны төрөл, урсгал чиглэлийг төлөөлсөн, үйл ажиллагаа эрхлэн явуулах зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй нийтдээ 372 сүм хийд, шашны байгууллага байгааг тоолж, бүртгэв. Эдгээрийн 28.5 хувийг Монголчуудын олонхи нь шүтдэг шашин болох бурханы шашны сүм хийд эзэлж байна. Бөө мөргөлийн зан үйлийн чиглэлээр шашны байгууллагын түвшинд үйл ажиллагаа явуулдаг 22 байгууллага бүртгэгдсэн нь нийт сүм хийдийн 5.9 хувьтай тэнцэж байв.

Хүснэгт 1. Нийт сүм хийдийн тоо, шашны төрлөөр

Байршил	Нийт сүм хийдийн тоо	Шашны төрлөөр					
		Будда	Христ	Ислам	Бөө мөргөл	Католик	Бусад (бахай, мүүн, шинто, хиндү)
Багануур	11	3	8				
Баянгол	59	24	23	1	10	1	
Баянзүрх	92	19	65		4	2	2
Налайх	16	3	11	2			
Сонгинохайрхан	72	19	49	1	2	1	
Сүхбаатар	44	10	24		6	1	3
Хан-Уул	38	13	23			2	
Чингэлтэй	40	15	25				
Нийслэлийн дүн	372	106	228	4	22	7	5

Тооллогын дүнгээс үзэхэд нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулж буй нийт сүм хийдийн ихэнх хэсэг буюу 61.3 хувь нь христийн шашны сүм, цуглаанууд байна.

Католик шашны тухайд 7 байгууллага нийслэлийн Багануур, Налайх, Чингэлтэй дүүргээс бусад дүүрэгт ажиллаж байгаагийн сацуу “бусад” буюу бахай шүтлэг, мүүн, шинто, хиндү шашныг төлөөлсөн 5 байгууллага байна.

Тоологдсон нийт сүм хийдийн 76.0 хувь буюу 283 сүм хийд нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах “албан ёсны зөвшөөрөлтэй” байна.


² Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, “Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм, хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох тухай журам”

Хүснэгт 2. Сүм хийдийн тоо, байршлаар

Байршил	Сүм хийдийн тоо, бүгд	Байршлаар			Бүгдээс: Зөвшөөрөлтэй сүм хийдийн тоо	Байршлаар		
		Байшин хороололд	Гэр хороололд	Холимог		Байшин хороололд	Гэр хороололд	Холимог
Багануур	11	4	7		4	1	3	
Баянгол	59	29	25	5	50	24	22	4
Баянзүрх	92	32	59	1	81	30	50	1
Налайх	16		16		5		5	
Сонгинохайрхан	72	14	57	1	49	11	37	1
Сүхбаатар	44	23	20	1	41	23	17	1
Хан-Уул	38	8	30		22	6	16	
Чингэлтэй	40	15	25		31	13	18	
Нийслэлийн дүн	372	125	239	8	283	108	168	7

Тоологдсон гурван сүм хийд тутмын нэг нь “байшин хороололд” байршиж байхад ихэнх буюу 64.2 хувь нь “гэр хороололд” төвлөрч байна. Ялангуяа, гэр хороололд байршилтай 239 сүм хийдийн 48.5 хувь нь нийслэлийн хүн ам хамгийн олноор суурьшдаг дүүргүүд болох Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн гэр хороололд байршин үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2. Нийт сүм хийдийн тоо, байршлаар, шашны төрлөөр



Нийслэлийн гэр хороололд христийн шашны 158 сүм хийд үйл ажиллагаа явуулж байгаа нь гэр хороололд байршилтай нийт сүм хийдийн 66.1 хувийг эзэлж байна. Эдгээрийн 98 нь албан ёсны зөвшөөрөлтэй, 38.0 хувь нь буюу 60 сүм, цуглаан зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байв.


Энд тодруулж тэмдэглэхэд Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт тоологдсон нийт сүм хийдийн 79.2 хувь, Хан-Уул дүүргийн сүм хийдийн 78.9 хувийг “гэр хороололд” байршилтай сүм хийд эзэлж байгаа юм. Ялангуяа Сонгинохайрхан дүүргийн 1, 2-р хорооны Толгойт бүс, Хан-Уул дүүргийн 14-р хорооны Өлзийт хороолол, Баянзүрх дүүргийн 2, 14, 19-р хорооны Дарь-Эх, Нарантуул зах, Шархад орчимд харьцангуй олон сүм хийд байна.

Хүснэгт 3. Нийт сүм хийд, үйл ажиллагаа явуулж буй ажлын байрны эзэмшлээр

	Сүм хийдийн тоо, бүгд	Байрны эзэмшлийн хэлбэрээр			Бүгдээс: Зөвшөөрөл -тэй сүм хийдийн тоо	Байрны эзэмшлийн хэлбэрээр		
		Өөрийн эзэмшлийн	Түрээсийн	Бусад		Өөрийн эзэмшлийн	Түрээсийн	Бусад
Багануур	11	8	2	1	4	4		
Баянгол	59	33	12	14	50	27	9	14
Баянзүрх	92	46	27	19	81	39	23	19
Налайх	16	12	1	3	5	4		1
Сонгинохайрхан	72	51	6	15	49	34	4	11
Сүхбаатар	44	17	8	19	41	17	8	16
Хан-Уул	38	23	5	10	22	13	3	6
Чингэлтэй	40	26	7	7	31	20	5	6
Нийслэлийн дүн	372	216	68	88	283	158	52	73

Нийслэлд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй нийт сүм хийдийн 55.8 хувь нь шашны зориулалтаар барьж, засч тохинуулсан “өөрийн эзэмшлийн барилга байгууламж, байранд” үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн 18.3 хувь нь “түрээсийн байранд”, 25.8 хувь нь “бусад” буюу сүм хийдийн тэргүүний хувийн эзэмшлийн гэрт эсвэл сүсэгтэн, итгэгчдийнхээ байр сууцанд үнэ хөлсгүй байрлаж, үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг байна.

Зураг 3. Үйл ажиллагаа явуулж буй байрны эзэмшлийн хэлбэр, шашны төрлөөр



Өөрийн эзэмшлийн байр, барилгатай шашны байгууллагуудын 55.0 хувийг христийн сүм цуглаанууд, 36.0 хувийг бурханы шашны дуган хийд эзэлж байна. Үйл ажиллагаагаа шашны байгууллагын тэргүүний хувийн гэр, сууцанд явуулах тохиолдол бурханы шашны дацан хийдэд илүүтэй байна. Тухайлбал, бурханы шашны 34 хийд тэргүүнийхээ хувийн эзэмшлийн гэрт эсвэл бусад төрлийн сууцанд байрлаж байв.

Энэ удаагийн тооллогоор, шашны байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулдаг байрны зөвхөн эзэмшлийн хэлбэрийг тодруулсан бөгөөд тохижилт, тав тухтай байдал талаас нь мэдээлэл аваагүй юм. Гэхдээ элэгдэж хуучирсан, өнгө зүс дулимаг, тохилог бус байранд ажиллаж буй сүм хийдтэй тооллогын явцад нэлээд таарч байв.

Зураг 4. Өөрийн эзэмшлийн байртай сүм хийд, шашны байгууллагууд

а. Буддын шашны хийд



б. Бөө мөргөл



в. Христийн шашны сүм



г. Исламын шашны сүм



д. Үнэн алдартны сүм



е. Католик сүм



ё. "Бахай шүтлэг"




Хүснэгт 4. Сүм хийдийн тоо, хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхээр

Байршил	Сүм хийдийн тоо, бүгд	Үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа эсэх		Бүгдээс: Зөвшөөрөл-тэй сүм хийдийн тоо	Үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа эсэх	
		Тийм	Үгүй		Тийм	Үгүй
Багануур	11	11	-	4	4	-
Баянгол	59	50	9	50	41	9
Баянзүрх	92	76	16	81	66	15
Налайх	16	16	-	5	5	-
Сонгинохайрхан	72	66	6	49	43	6
Сүхбаатар	44	35	9	41	33	8
Хан-Уул	38	33	5	22	18	4
Чингэлтэй	40	32	8	31	24	7
Нийслэлийн дүн	372	319	53	283	234	49

Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулж байгаа 372 сүм хийдийн дийлэнх буюу 319 сүм хийдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байв. Энэ нь тоологдсон нийт сүм хийдийн 85.8 хувийг эзэлж байгаа юм. Харин зөвшөөрөл авсан шашны байгууллагуудын тухайд авч үзэхэд 234 сүм хийд буюу дийлэнх хэсэг нь (82.7%) үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Зураг 5. Үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа сүм хийд, дүүргээр, хувиар



Үйл ажиллагаагаа “хэвийн явуулж байгаа” таван сүм хийд тутмын нэг нь Баянзүрх дүүрэгт ногдож байгаа бол 17.7 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 13.5 хувь нь Баянгол дүүрэгт байна. Харин тодорхой шалтгааны улмаас үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа сүм хийд нийслэлийн хэмжээнд 53 байгаагийн 49 нь албан ёсны зөвшөөрөлтэй байв.

❖ Салбар сүм хийд, шашны байгууллагатай сүм хийд

Нийслэлийн нутаг дэвсгэрт салбар сүм хийд, шашны байгууллагатай 45 сүм хийдийг тоолов. Эдгээрийн 34 нь христийн сүм, 7 нь бурханы шашны дацан хийд байгаа бол исламын шашны хоёр, бөө мөргөл, бахайн шашны байгууллага тус бүр нэг салбартай байна.

Хүснэгт 5. Салбар сүм хийд, шашны байгууллагатай сүм хийд, шашны төрлөөр

Байршил	Нийт сүм хийдийн тоо	Үүнээс: Салбар сүм хийдтэй	Шашны төрлөөр					
			Будда	Христ	Ислам	Бөө мөргөл	Католик	Бусад (бахай, мүүн, шинто, хиндү)
Багануур	11	2		2				
Баянгол	59	9	3	5	1			
Баянзүрх	92	15	1	13		1		
Налайх	16	-						
Сонгинохайрхан	72	11	2	8	1			
Сүхбаатар	44	2		1				1
Хан-Уул	38	1		1				
Чингэлтэй	40	5	1	4				
Нийслэлийн дүн	372	45	7	34	2	1	-	1

Салбар сүм хийдтэй христийн шашны байгууллагууд нийслэлийн Налайх дүүргээс бусад бүх дүүрэгт байгаагийн дотор 38.2 хувь нь Баянзүрх, 23.5 хувь нь Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг байна.

Хүснэгт 6. Сүм хийдийн тоо, салбартай эсэхээр

Байршил	Нийт сүм хийдийн тоо	Үүнээс: Зөвшөөрөл авсан сүм хийд	Салбар сүм хийдтэй эсэх	
			Тийм	Үгүй
Багануур	11	4	1	3
Баянгол	59	5	8	42
Баянзүрх	92	81	15	66
Налайх	16	5		5
Сонгинохайрхан	72	49	10	39
Сүхбаатар	44	41	2	39
Хан-Уул	38	22	1	21
Чингэлтэй	40	31	5	26
Нийслэлийн дүн	372	283	42	241

Дээрх мэдээллийг албан ёсны зөвшөөрөлтэй сүм хийдээр салгаж үзэхэд 14.8 хувь нь буюу 42 сүм хийд "салбартай" байв.

Салбар сүм хийдтэй шашны байгууллагуудын 78.6 хувь нь Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байршиж байна.

Баянзүрх дүүрэгт байрлах Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм нь нийслэлийн төвийн зургаан дүүргээс гадна Налайх, Багануур дүүрэгт салбартай байв. Тус сүмийн эдгээр салбарууд зөвшөөрөлгүй үйл

ажиллагаа явуулж, төв сүмийнхээ зөвшөөрөл авсан огноо, регистрийн дугаарыг ашигладаг бөгөөд мөн санхүүгийн тамга тэмдгээ ч энэ жишгээр хийж ашиглаж байгаа нь тооллогын асуулгын мэдээллээс тодорхой харагдаж байв.

Нийслэлийн Багануур, Сонгинохайрхан дүүрэгт христийн сүм тус бүр нэг, Баянгол дүүрэгт исламын шашны нэг байгууллага, нийтдээ 3 сүм зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ улмаар салбар сүм хийд “давхар ажиллуулдаг” болохыг тогтоосон юм. Аймаг, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг салбар сүм хийд тооллогод хамрагдах боломжгүй байсан хэдий ч нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа салбаруудыг бүрэн тоолсон болно.

❖ Сүм хийд, шашны байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ


Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 74 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ын 5.6-д “Зөвшөөрөлд заагдсан нутаг дэвсгэрээс өөр байршилд үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан байдаг. Тус заалтын хэрэгжилтийг тандах зорилгоор шашны байгууллага, сүм хийдийн үйл ажиллагааны цар хүрээг тооллогын товын үеэр тодруулсан юм.

Хүснэгт 7. Сүм хийдийн тоо, үйл ажиллагааны цар хүрээгээр

Байршил	Нийт сүм хийдийн тоо	Үйл ажиллагааны цар хүрээ			
		Улсын хэмжээнд	Зарим аймаг, орон нутагт	УБ хотын хэмжээнд	Дүүрэг, хорооны түвшинд
Багануур	11	-	-	-	11
Баянгол	59	2	3	21	33
Баянзүрх	92	1	9	50	32
Налайх	16	-	-	1	15
Сонгинохайрхан	72	-	8	2	62
Сүхбаатар	44	-	1	26	17
Хан-Уул	38	-	-	4	34
Чингэлтэй	40	1	1	17	21
Нийслэлийн дүн	372	4	22	121	225

Нийт сүм хийдийн 60.5 хувь буюу 225 сүм хийд нийслэлийн дүүрэг, хороодын түвшинд үйл ажиллагаа явуулж байгаагийн 65.8 хувь нь “зөвшөөрөлтэй” сүм хийд байна.

Зураг 6. Сүм хийдийн тоо, байршил, үйл ажиллагааны цар хүрээгээр



Өөрөөр хэлбэл дээрх журмын холбогдох заалтыг бүрэн утгаар нь биелүүлж, зөвшөөрөлд заагдсан нутаг дэвсгэр, байршилд үйл ажиллагаа явуулж байгаа гэж үзэх үндэслэлтэй 148 сүм хийд тоологдсон байна. Мөн эдгээр сүм хийдтэй зэрэгцэн “зөвшөөрөлгүй” 77 сүм хийд ажиллаж байв. Нийслэлийн дүүрэг, хороодын түвшинд зөвшөөрөлгүй ажиллаж буй шашны байгууллагуудын ес нь буддын, нэг нь исламын шашны байгууллага байхад 67 нь христийн шашны сүм, цуглаанууд байна.

Уламжлалт бурханы шашны хийгээд христийн зарим томоохон сүм, цуглааны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог шинж, сүсэгтэн олон, итгэгчдийн сүсэг бишрэл, хандлагаас хамаарч Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сүм хийд 121 байна. Ойролцоогоор гурван сүм хийд тутмын нэг нь буюу 32.5 хувийг эдгээр сүм хийд эзэлж байв.

Хүснэгт 8. Сүм хийдийн тоо, үйл ажиллагааны цар хүрээгээр, зөвшөөрөлтэй эсэхээр

Байршил	Нийт сүм хийдийн тоо	Үйл ажиллагааны цар хүрээ							
		Улсын хэмжээнд		Зарим аймаг, орон нутагт		УБ хотын хэмжээнд		Дүүрэг, хорооны түвшинд	
		Шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй эсэх							
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Багануур	11							4	7
Баянгол	59	1	1	3		20	1	26	7
Баянзүрх	92	1		9		47	3	24	8
Налайх	16						1	5	10
Сонгинохайрхан	72			7	1	1	1	41	21
Сүхбаатар	44			1		26		14	3
Хан-Уул	38					4		18	16
Чингэлтэй	40	1		1		13	4	16	5
Нийслэлийн дүн	372	3	1	21	1	111	10	148	77

Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сүм хийдийн 41.3 хувь нь Баянзүрх, 21.5 хувь нь Сүхбаатар, 17.3 хувь нь Баянгол, 14.0 хувь нь Чингэлтэй дүүрэгт байна. Түүнчлэн үйл ажиллагааны цар хүрээ нь Улаанбаатар хотын хэмжээнд төвлөрч буй эдгээр шашны байгууллагуудын 91.7 хувийг “зөвшөөрөлтэй” сүм хийд эзэлж байв. Тухайлбал, бурханы шашны 31 хийд, үнэн алдартны шашны төлөөлөл ороод христийн шашны 62, бөө мөргөлийн 12, католик сүм хоёр, бусад шашны сүм цуглаан дөрөв байна.

Харин улс орон даяар ажилладаг хэмээн бүртгүүлсэн сүм хийд 4, зөвшөөрөлд заагдсан нутаг дэвсгэрээс шууд утгаараа өөр байршилд буюу зарим аймаг, орон нутгийн хэмжээнд ажилладаг гэж мэдээлсэн 22 сүм хийдийг тоолсон.

Эдгээр нь гол төлөв салбар сүм хийдээрээ дамжуулан аймаг, орон нутагт ажилладаг сүм хийд юм. Үйл ажиллагаагаа сурталчлан дэлгэрүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа христийн сүмүүдээс гадна бурханы шашны байгууллагууд хот, хөдөөд лам хуврагуудаа тогтмол хугацаанд илгээж, шашнаас илүүтэй сүсэгтэн олонд зориулан уламжлалт зан заншил, соёл, түүнийг хэрхэн хадгалж, хамгаалж үлдэх, амьдралын учир шалтгаан, хүмүүс хоорондоо эв түнжинтэй байх талаар яриа таниулга хийж, ном хурах, бөө нар хөдөө гарч бөөлөх зэрэг бөө мөргөлийн болон шашны бусад зан үйл, үйлчилгээ энд бас давхар хамаарч байгааг шашны байгууллагууд онцлон тодотгож байсныг дурдах нь зүйтэй болов уу.

ГУРАВ. АЛБАН ЁСНЫ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ СҮМ ХИЙД

Монгол Улсын “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хууль хэрэгжиж эхэлсэн 1994 оноос хойш 2014 оныг дуусталх 20 жилийн хугацаанд НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөл олгогдсон сүм хийдүүдээс урьд өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан, тооллогын товын үеэр үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдийг бүртгэлжүүлж, тооллогод хамруулсан.

Тооллогод хамрагдаж, бүртгэгдсэн 372 сүм хийдийн 76.0 хувь буюу 283 сүм хийд, шашны байгууллага нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах “албан ёсны зөвшөөрөлтэй” байна.

Энэ удаагийн тооллогоор Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хамгийн олон буюу 92 сүм хийд тоологдсоны 88.0 хувийг зөвшөөрөлтэй сүм хийд эзэлж байна.

Сүм хийдийн тоогоор нийслэлийн хэмжээнд Сонгинохайрхан дүүрэг (72) удаалж байгаа хэдий ч нийт дүнд зөвшөөрөлтэй сүм хийдийн эзлэх хувийн жин харьцангуй бага байв. Энэ нь тус дүүрэгт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг сүм хийд цөөнгүй байгааг илтгэж буй хэрэг юм.


Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулж байсан 59 сүм хийдийн 84.7 хувь, Сүхбаатар дүүргийн 44 сүм хийдийн 93.2 хувь нь зөвшөөрөлтэй байв.

Төвийн зургаан дүүрэг дотроо цөөн тооны сүм хийдтэй дүүрэгт тооцогдох Чингэлтэй дүүргийн сүм хийдийн 77.5 хувь, Хан-Уул дүүргийн сүм хийдийн 58.0 хувь нь зөвшөөрөлтэй ажээ. Өөрөөр хэлбэл, Чингэлтэй дүүргийн нийт сүм хийдийн 22.5 хувь, Хан-Уул дүүргийн нийт сүм хийдийн 42.0 хувь нь НИТХ-ын Тэргүүлэгчдээс албан ёсны шийд олгоогүй байхад дур мэдэн зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгааг тооллогын явцад илрүүлэв.

Энэ байдал нийслэлийн алслагдсан дүүргүүдэд ч нийтлэг үзэгдэл болсон байв. Тухайлбал, Налайх, Багануур дүүрэгт ажиллаж буй сүм хийдүүдийн 63.6-68.7 хувь нь шашны үйл ажиллагаа явуулах “зөвшөөрөлгүй” бөгөөд дөнгөж 31.3-36.4 хувийг албан ёсны зөвшөөрөлтэй сүм хийд эзэлж байгаа юм.

Багахангай дүүргийн хувьд зөвшөөрөлтэй сүм хийд огт байхгүй бөгөөд үүнд цөөн хүн амтай байдал нөлөөлдөг бололтой. Тус дүүрэгт “Амийн гол” нэртэй христийн салбар цуглаан бий гэсэн мэдээллийг нягталж үзэхэд библи уншиж, судлах чиглэлээр зөвхөн гэр бүлийн цөөн гишүүдийн хүрээнд, тогтмол бус хугацаанд цуглардаг болохыг дүүргийн холбогдох ажилтан баталсан тул тооллогод хамруулаагүй болно.

Зураг 7. Зөвшөөрөлтэй сүм хийд, дүүргээр




Хүснэгт 9. Зөвшөөрөлтэй сүм хийдийн тоо, шашны төрлөөр

Байршил	Нийт сүм хийдийн тоо	Үүнээс: Зөвшөөрөлтэй сүм хийд	Шашны төрлөөр					
			Будда	Христ	Ислам	Бөө мөргөл	Католик	Бусад (бахай, мүүн, шинто, хиндү)
Багануур	11	4	2	2				
Баянгол	59	50	23	17		9	1	
Баянзүрх	92	81	17	56		4	2	2
Налайх	16	5	2	2	1			
Сонгинохайрхан	72	49	17	28	1	2	1	
Сүхбаатар	44	41	10	21		6	1	3
Хан-Уул	38	22	10	10			2	
Чингэлтэй	40	31	13	18				
Нийслэлийн дүн	372	283	94	154	2	21	7	5

Албан ёсны зөвшөөрөлтэй гурван сүм хийд тутмын нэг нь “бурханы шашны хийд, дацан” байна. Зөвшөөрөлтэй сүм хийдийн дүнд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “бөөгийн шашны” эзлэх хувийн жин харьцангуй бага гарч, 7.4 хувьтай байна. Харин талаас илүү буюу 54.4 хувийг “христийн шашны сүм, цуглаан” эзэлж байв.

Эндээс үзэхэд, хэдийгээр нийслэлийн иргэдийн шүтэх бишрэх эрхийг хангах үүднээс төвийн болон алслагдсан дүүргүүдийн нутаг дэвсгэрт бурханы шашны болон христийн шашны аль аль нь тархан байршсан хэдий ч уламжлалт болон уламжлалт бус шашны байгууллага хоорондын тооны зохистой харьцаа алдагдаж, христийн шашны сүм цуглааны тоо хэт олшрох хандлага үүссэн байна. Тухайлбал, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй нийт сүм хийдийн 69.0 хувь, Чингэлтэй дүүргийн сүм хийдийн 58.1 хувь, Сонгинохайрхан дүүргийн сүм хийдийн 57.0 хувь, Сүхбаатар дүүргийн сүм хийдийн талаас илүү хувийг христийн шашны сүмүүд эзэлж байна.

Зураг 8. Зөвшөөрөлтэй сүм хийд, хувиар, шашны төрлөөр



Манай оронд хэдэн жилийн өмнөөс эхлэн бөө нар маш олноор төрөн гарч, бөөгийн онгод бараг айл бүрт ирж төрөн, ахан дүүс бүхэн удмын бөөтэй болж байгаа талаар их ярьж, бичиж байна. Улмаар энэ хандлага нийгмийн үзэгдэл болох талруугаа хэлбийж, хэтэрхий туйлшран, бизнесийн шинж төрхтэй боллоо хэмээн ихээхэн шүүмжлэлд өртөөд байгаа билээ.

Чингэлтэй, Хан-Уул дүүргээс бусад нийслэлийн төвийн зарим дүүрэгт, 4-5 төрлийн шашны төлөөлөл үйл ажиллагаа явуулж байхад бөө мөргөлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан шашны байгууллага Багануур, Налайх дүүрэгт төдийгүй төвийн Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт нэг ч байхгүй байсан нь сонирхол татаж байв.

Хэдийгээр бөөгийн онгод буулгадаг хувь хүмүүс олширсон боловч бөө мөргөлийн зан үйлийн үйлчилгээг шашны байгууллагын зохион байгуулалт дор нэгтгэж, сүсэгтэн олонд хүргэж үйлчлэх албан ёсны зөвшөөрөл авсан байгууллага нийслэлд харьцангуй цөөн байгааг дээрх мэдээлэл харуулав.

Зөвшөөрөлтэй сүм хийдийн дүнд хамгийн бага хувийн жин эзэлж буй шашны төрөлд бөө мөргөл, католик, исламын шашин орж байгаагийн зэрэгцээ бахай шүтлэг, мүүнийн шашин мөн сүүлийн жилүүдэд Монголын нийгэмд нэвтэрч эхлээд удаагүй байгаа шинто, хиндү шашны байгууллагууд орж байна.

Хүснэгт 10. Зөвшөөрөлтэй сүм хийдийн үйл ажиллагааны байдал

Байршил	Нийт сүм хийдийн тоо, бүгд	Бүгдээс: Зөвшөөрөлтэй сүм хийдийн тоо	Үйл ажиллагаагаа жилийн турш явуулдаг эсэх		
			Жилийн турш	Улирлын чанартай	бусад
Багануур	11	4	4	-	-
Баянгол	59	50	40	1	9
Баянзүрх	92	81	65	1	15
Налайх	16	5	5	-	-
Сонгинохайрхан	72	49	43	-	6
Сүхбаатар	44	41	31	2	8
Хан-Уул	38	22	18	-	4
Чингэлтэй	40	31	22	2	7
Нийслэлийн дүн	372	283	228	6	49

"Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам"-ын 5.1-д *"Зөвшөөрөл авсан сүм хийд, цугларалтын үйл ажиллагаанд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Шашин сүм хийдийн асуудал эрхэлсэн ажлын хэсэг болон Тэргүүлэгчдээс хяналт тавьж ажиллана"* гэж заасан.

Тус ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүднээс зөвшөөрөл авсан сүм хийдийн үйл ажиллагаа тогтвортой бөгөөд тасралтгүй явагдаж байгаа эсэхийг тодруулах асуултыг тооллогын асуулгад тусгасан.

Тооллогын мэдээллээс харахад зөвшөөрөл авсан сүм хийд, шашны байгууллагуудын дийлэнх буюу 80.6 хувь нь үйл ажиллагаагаа жилийн турш явуулдаг байна. Энэ нь нийслэлийн хэмжээнд байгаа уламжлалт болон уламжлалт бус шашны байгууллага, сүм хийдийн үйл ажиллагаа бүхэлдээ тогтмолжиж, жигдэрсэн гэсэн үг юм.

Бүтэн жилийн турш үйл ажиллагаа явуулдаг сүм хийдүүдийн 65.0 хувь нь Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байршдаг ажээ. Маш цөөн тооны сүм хийд улирлын чанартай ажилладаг байна. Харин үлдэж буй хэсэгт зөвшөөрөл авсан боловч тодорхой шалтгаануудын улмаас үйл ажиллагаагаа "хэвийн явуулж чадахгүй байгаа" 49 сүм хийд багтаж байгаа юм.

Хүснэгт 11. Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа сүм хийд, шалтгаанаар

Байршил	Зөвшөөрөлтэй сүм хийдийн тоо	Үүнээс: Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа сүм хийдийн тоо	Үйл ажиллагаагаа хэвийн явуулаагүй шалтгаан:						
			Үйл ажиллагаа эхлээгүй	Түр зогссон	Санхүүгийн эх үүсвэргүй	Ажлын байргүй	Бүрэн зогссон	Татан буугдахаар болсон	Бусад
Багануур	4	-							
Баянгол	50	9	2	2		3			2
Баянзүрх	81	15		2	1	2	1	7	2
Налайх	5	-							
Сонгинохайрхан	49	6		3	1		1		1
Сүхбаатар	41	8					4	1	3
Хан-Уул	22	4	2				1		1
Чингэлтэй	31	7				2	1		4
Нийслэлийн дүн	283	49	4	7	2	7	8	8	13

Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа эрхлэн явуулах зөвшөөрөл авсан хэдий ч зарим сүм хийд, шашны байгууллагуудыг үйл ажиллагаагаа хэвийн хэмжээнд явуулж чадахгүйд хүргэсэн голлох шалтгаануудад санхүүжилтын асуудалтай холбоотой түр болон бүрэн зогсолт, үйл ажиллагаа явуулж байсан байр танхимаа бусдад түрээслүүлсэн, гэр хорооллын газрын дахин төлөвлөлтөд орсон, барилга байшин нь шатсан зэргээр “ажлын байргүй болсон явдал” зонхилж байв.

НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гарч, зөвшөөрөл албан ёсоор олгогдсоноос хойш тодорхой цаг хугацаа өнгөрөөд байгаа ч холбогдох бичиг баримт, газрын асуудлаа шийдвэрлэж чадалгүй өнөөг хүрсэн гэх мэт шалтгааны улмаас “үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй” сүм хийд дөрөв байна. Түүнчлэн үйл ажиллагааны хэвийн байдал нь доголдож, цаашдаа тогтвортой ажиллах эсэх нь тодорхойгүй болсон зарим нэг сүм хийд татан буугдах хэмжээнд хүрсэн байна.

Тооллогын товын үеэр тухайн сүм хийд, шашны байгууллагыг үүсгэн байгуулагч нас барсан, тэргүүнээр ажиллаж байсан хүн нь Солонгос, Америк, ОХУ-ын Буриад, Япон зэрэг гадаад улс оронд суралцаж, амьдарч байгаа тул ажил үүргийг нь хариуцаж үлдсэн хүмүүс идэвх зүтгэл гаргалгүй хайхрамжгүй хандаж, үйл ажиллагааг нь цалгардуулсан эсвэл хариуцах тодорхой хүнгүй болж эзэнгүйдсэн байдал цөөнгүй тохиолдсон тул “бусад” гэсэн шалтгаанд оруулсан. Мөн тооллогын ажилтанд тухайн сүм хийдтэй холбоотой ямар ч бичиг баримт байхгүй мэтээр тайлбарлах, бүр мэдээлэл өгөхөөс цааргалах оролдлого ч гаргаж байв.

❖ Санхүүгийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ тайлан гаргадаг байдал

Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа эрхлэн явуулахаар зөвшөөрөл авсан сүм хийд, шашны байгууллагуудын 74.6 хувь нь буюу 211 сүм хийд санхүүгийн тайлан тэнцэл гаргаж, 25.4 хувь нь “тайлан тэнцэл огт гаргадаггүй” байна. Санхүүгийн тайлан тэнцэл гаргадаггүй гэж мэдээлсэн сүм хийдийн 27 нь буюу 37.5 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулдаг байна.

Хүснэгт 12. Сүм хийдийн тоо, санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг эсэхээр

Байршил	Зөвшөөрөл авсан сүм хийдийн тоо	Санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг эсэх		Хэрэв тайлан тэнцэл гаргадаггүй бол үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа эсэх	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Багануур	4	4	-	-	-
Баянгол	50	36	14	5	9
Баянзүрх	81	62	19	5	14
Налайх	5	4	1	1	-
Сонгинохайрхан	49	34	15	9	6
Сүхбаатар	41	31	10	3	7
Хан-Уул	22	16	6	2	4
Чингэлтэй	31	24	7	2	5
Нийслэлийн дүн	283	211	72	27	45


Зураг 9. Тайлан гаргадаггүй сүм хийд

Шашны байгууллагууд ихэвчлэн төрийн бус “ашгийн бус байгууллагад” хамаардаг тул албан бус мэдээллээс үзэхэд татварын байгууллагууд сүм хийд нэг бүрээс санхүүгийн тайлан баланс гаргаж, харъяалах татварын хэлтэст мэдээлж байх шаардлага тэр бүр тавьдаггүй байна.

Энэ байдлаас шалтгаалан сүм хийд, шашны байгууллагууд хэвийн үйл ажиллагаа явуулж байлаа ч санхүүгийн тайлан тэнцэл гаргаж, татварт мэдээлэхгүй үлдэхэд нөлөөлдөг байж болох талтай.

Гэхдээ ард, иргэдийнхээ шүтэх эрх чөлөөг дээдэлдэг гадаадын зарим улс оронд шашны байгууллагаа татвараас чөлөөлдөг практик байдгийг дурдахад илүүдэхгүй юм.

Зөвшөөрөлтэй хэдий ч санхүүгийн тайлан тэнцэл гаргадаггүй сүм хийдийг шашны төрлөөр нь авч үзэхэд ихэнх хэсэг нь буюу 56.9 хувийг бурханы шашны байгууллагууд эзэлж байв. Мөн христийн шашны 21 сүм, бөөгийн мөргөлийн 7, ислам, католик болон бусад шашны тус бүр нэг байгууллага тайлан тэнцэл огт гаргадаггүй байна.



Хүснэгт 13. Сүм хийдийн тоо, санхүүгийн тайлан гаргадаг ажилтантай эсэхээр

Байршил	Зөвшөөрөл авсан сүм хийдийн тоо	Санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг ажилтны байдал			
		Байгууллагын нягтлан	Гэрээт нягтлан	Бусад	Тодорхойгүй
Багануур	4	-	4	-	-
Баянгол	50	13	14	17	6
Баянзүрх	81	14	12	54	1
Налайх	5	1	1	2	1
Сонгинохайрхан	49	4	16	27	2
Сүхбаатар	41	8	13	17	3
Хан-Уул	22	4	10	7	1
Чингэлтэй	31	9	8	11	3
Нийслэлийн дүн	283	53	78	135	17

Зөвшөөрөлтэй сүм хийдийн 18.7 хувь нь байгууллагын нягтлантай бол 27.6 хувь нь гэрээт нягтлангаар тайлан балансаа гаргуулдаг байна. Түүнчлэн эдгээрээс бусад гэсэн хариултыг 47.7 хувь нь сонгосон байв. Тодруулбал, шашны байгууллагын үндсэн ажилтан эсвэл санхүүгийн мэдлэгтэй итгэгч, тэрчлэн сүм хийдийн тэргүүн нь өөрөө тайлан балансаа гаргах тохиолдол түгээмэл байна.

Хүснэгт 14. Сүм хийд, статистик мэдээ гаргадаг эсэхээр


Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй нийт сүм хийдийн 54.5 хувь нь статистикийн мэдээ тайланг тогтмол гаргаж, мэдээлж хэвшсэн, 4.2 хувь нь "тогтмол бус", 41.3 хувь нь "огт өгдөггүй" байна.

Албан ёсны статистикийн мэдээ тайланг тогтмол мэдээлж хэвшсэн гурван сүм хийд тутмын нэг нь нийслэлийн Баянзүрх дүүргийнх байна.

Огт мэдээлдэггүй сүм хийдийн тоонд тодорхой шалтгааны улмаас үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй болсон, санхүүгийн тайлан тэнцэл гаргадаггүй, эсвэл шинээр байгуулагдсан сүм хийд багтсан төдийгүй хэвийн үйл ажиллагаатай зарим шашны байгууллагууд ч орсон байв.

Байршил	Зөвшөөрөл авсан сүм хийдийн тоо	Статистикийн мэдээ тайланг тогтмол гаргаж өгдөг эсэх		
		Тогтмол	Тогтмол бус	Огт өгдөггүй
Багануур	4	4	-	-
Баянгол	50	25	1	24
Баянзүрх	81	52	3	26
Налайх	5	4	1	-
Сонгинохайрхан	49	23	4	22
Сүхбаатар	41	18	3	20
Хан-Уул	22	12	-	10
Чингэлтэй	31	16	-	15
Нийслэлийн дүн	283	154	12	117

Зураг 10. Статистикийн тайлан мэдээ гаргадаг сүм хийд, шашны төрлөөр, хувиар



Албан ёсны статистикийн мэдээ тайланг тогтмол мэдээлж хэвшсэн 154 сүм хийдийн 35.0 хувийг христийн шашны байгууллагууд, 14.5 хувийг бурханы шашны хийд, дацан эзэлж байна. Статистикийн мэдээ тайланг тогтмол гаргаж мэдээлдэг сүм хийдийн дүнд бөөгийн шашны эзлэх хувь 2.1, католик шашных 1.4, исламын шашных 0.4 байхад бусад буюу мүүн, бахай шүтлэг, шинто шашин 1.1 хувьтай байв.

Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ, регистрийн дугаар аваагүй тохиолдол шинэ тутамд байгуулагдсан сүм хийд, цуглаануудад цөөнгүй гарч байна. Энэ нь ҮСХ-ны бизнес регистрийн санд бүртгэгдэхгүй үлдэх гол шалтгаан болж, улмаар статистикийн мэдээ тайланг мэдээлэх боломжгүй нөхцөл байдал үүсгэхэд хүргэдэг байна.

ДӨРӨВ. ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА ХЭТЭРСЭН СҮМ ХИЙД

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 74 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ын 3.6-д “Зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгоно” гэж заасан.

Хүснэгт 15. Зөвшөөрлийн хугацаа хэтэрсэн сүм хийдийн тоо, шашны төрлөөр

Байршил	Зөвшөөрөлтэй сүм хийдийн тоо	Үүнээс: Зөвшөөрлийн хугацаа хэтэрсэн сүм хийд	Шашны төрлөөр					
			Будда	Христ	Ислам	Бөө мөргөл	Католик	Бусад (бахай, мүүн, шинто, хиндү)
Багануур	4	1	1					
Баянгол	50	28	17	3		8		
Баянзүрх	81	36	16	20		1	1	
Налайх	5	3	1	1	1			
Сонгинохайрхан	49	25	11	11	1	2		
Сүхбаатар	41	26	7	14		5		
Хан-Уул	22	8	5	3				
Чингэлтэй	31	19	9	10				
Нийслэлийн дүн	283	146	65	62	2	16	1	-

Тооллогын товын үеэр, зөвшөөрөлтэй 283 сүм хийдийн талаас илүү (51.6%) хувь буюу 146 сүм хийдийн өмнө олгогдсон зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа хэтэрсэн байв. Эдгээрийн дотор, зөвшөөрөл анх олгохдоо хүчинтэй байх хугацааг “байнга” хэмээн тодотгосон дараах зургаан шашны байгууллага орсон. Тухайлбал, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай Төгсбаясгалант хийд, Гандантэгчэнлин хийд, өмнө нь Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байсан Улаанбаатар дахь Христосын чөлөөт сүм, Налайх дүүргийн Мекке исламын сүм, Сонгинохайрхан дүүргийн Намдолдэчэнлин хийд, христийн шашны Баянхошуу цуглаан орж байгаа юм.

Зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн бурханы шашны болон христийн шашны сүм хийдийн тоо ойролцоо түвшинд байна. Гэхдээ бурханы шашны 65 хийдийн 17 нь Баянгол дүүргийн, христийн 62 сүм цуглааны 32.3 хувь нь Баянзүрх дүүргийнх байна. Харин зөвшөөрлийн хугацааг хэтрүүлсэн бөөгийн ихэнх шашны байгууллага нийслэлийн Баянгол, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байршдаг ажээ.


Исламын шашны хоёр сүмийн хоёулангийнх нь зөвшөөрлийн хугацаа хэтэрч, католик шашны нэг сүмийн зөвшөөрлийн хугацаа дууссан бол бусад шашны байгууллагуудын хувьд журмын заалт зөрчсөн тохиолдол гаргаагүй байна.

Сүм хийд, шашны байгууллагуудын зөвшөөрлийн хугацаа хэтэрсэн хоёр төрлийн хэлбэр байна. Үүний эхний хэлбэрт зөвшөөрөл анх авсан хугацаанаас хойш “нэг ч удаа сунгалт хийлгээгүй” сүм хийд, шашны байгууллагууд багтаж байгаа бөгөөд ийм байдлаар зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн сүм хийд нийслэлийн хэмжээнд 58 байна. Эдгээрийн 28 нь бурханы шашны, 23 нь христийн, 6 нь бөө мөргөлийн, исламын шашны нэг сүм байна.

Зөвшөөрлийн хугацааг хэтрүүлж буй хоёр дахь хэлбэрт “сунгалтын хугацааг хэтрүүлсэн” сүм хийд хамаарч байна. “Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ын 4.2-д “...бусад асуудлыг хэлэлцэн зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар сунгаж болно” гэж заасан.

Зураг 11. Зөвшөөрлийн хугацааны хэтрэлт, жилээр

Тооллогын товын байдлаар, тухайн сүм хийдийн зөвшөөрлийг хамгийн сүүлд сунгалт хийснээс хойш нэг болон түүнээс дээш жилээр “хугацаа хэтрүүлсэн” 88 сүм хийд байгааг тоолов. Энэ нь зөвшөөрлийн хугацаа хэтэрсэн нийт сүм хийдийн 60.3 хувийг эзэлж байв.



Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа нь дуусаад “нэг жил” өнгөрч байгаа сүм хийд 33 байгаагийн 25 нь христийн шашны сүм, цуглаанууд байна.

Зөвшөөрлийн хугацааг олон жилээр хэтрүүлэх зөрчил бурханы шашны байгууллагуудад нийтлэг байна. Тухайлбал, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь дуусаад 4-5 жил болсон сүм хийд нийслэлд 15 байгаагийн арав нь, 8-9 жил өнгөрөөд байгаа 7 сүм хийдийн тав нь, 10 ба түүнээс дээш жилээр хугацаа хэтрүүлсэн 9 сүм хийд бүгд бурханы шашны сүм хийд байв.

Нөхцөл байдал ийм байгаатай шашны байгууллагууд санал нийлж байгаагийн зэрэгцээ зөвшөөрлийн сунгалт хийлгэхэд шаардагдах баримт материалаа зохих журмын дагуу бүрдүүлж, аль болох тогтоосон хугацаанаас өмнө НИТХ-ын Ажлын Албанд хүргүүлдэг боловч асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэх байдал удаашралтай байна гэсэн тайлбарыг сүм хийд, шашны байгууллагуудын зүгээс өгч байв.

Зөвшөөрөл авсан сүм хийдийг бүртгэлжүүлэх ажил системтэй бус байсны улмаас шашны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих асуудалд хүндрэл бэрхшээл байнга тулгарсаар ирсэн. Үүний нэг тод жишээ нь, хугацаа сунгалтад тавих хяналт бөгөөд үүнээс гадна тухайн сүм хийдэд үйл ажиллагаа явуулах тухай албан ёсны зөвшөөрөл аль хэдийнэ олгогдчихсон байтал тэр талаарх мэдээллийг шашны байгууллагууд олж мэдэлгүй цаг алдах, асууж лавласан хэрнээ зөвшөөрөл гараагүй гэх ташаа мэдээлэл сонсох, үүний улмаас улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, аж ахуйн нэгж байгууллагын гэрчилгээ, регистрийн дугаар авч чадахгүй байх явдал олонтоо гардаг гэдгийг өмнө дурдсан. Зөвшөөрөл олгогдсон талаар нэлээд хожуу хойно, тухайн сүм хийд дээр очсон манай тооллогын ажилтнуудаас анх удаагаа сонсож, мэдсэн тохиолдол ч нэг бус удаа гарсан.

Тооллогын товын үеэр, зөвшөөрөл авсан 35 сүм хийдийн дүүрэг, хорооны байршил тодорхойгүй, байгууллагын болон тэргүүний регистрийн дугаар, шашны төрөл, урсгал, харилцах утас байхгүй, мэдээлэл дутуу тул тооллогын асуултын хариултыг авч чадахгүй байв. Иймд зөвшөөрөл авсан хугацаанаас хойш “нэг ч удаа сунгалт хийлгээгүй” эсвэл хугацаа хэтрүүлсэн сүм хийдийг тухайн хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч, дүүргийн хурлын байгууллагын холбогдох ажилтан, ойр орчмын оршин суугчдын өгсөн мэдээллийн дагуу эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулсан.

Тодорхойгүй, дутуу байгаа мэдээллийг тодруулж, бүрдүүлэх энэ ажлын хүрээнд Нийслэлийн Архивын газарт албан бичиг хүргүүлж, тус архивын сан хөмрөгт хадгалагдаж буй НИТХ-ын 1996-2007 оны баримтаас нийслэлийн шашин, сүм хийдтэй холбоотой баримт, хурлын тэмдэглэл зэрэг 68 хадгаламжийн нэгжээс тооллогын 5 ажилтан мэдээлэл шүүж, түүвэрлэлт хийсэн боловч 29 сүм хийдийн мэдээллийг бүрэн бүрдүүлж чадаагүй, зөвхөн 6 сүм хийдийн мэдээллийг бүрэн бүрдүүлэв.

ТАВ. СҮМ ХИЙД, ШАШНЫ БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГЧИД

Энэ удаагийн тооллогоор нийслэлийн сүм хийд, шашны байгууллагад ажиллагчдын тоо, бүтцийн талаарх мэдээллийг “үндсэн” болон “сайн дурын” ажиллагчид, нийт ажиллагчдаас “эмэгтэй” болон “гадаадын ажиллагчид” гэсэн үзүүлэлтээр цуглуулж, дараах мэдээллийг бүрдүүлэв.

❖ Сүм хийдийн үндсэн ажиллагчид

Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй 283 сүм хийдэд нийтдээ 1921 хүн үндсэн ажилтнаар бүртгэгдэн ажилладаг байна. Шашны байгууллагуудын үндсэн ажиллагчдын 63.5 хувь нь бурханы шашны байгууллагуудад, 31.2 хувь нь христийн шашны сүм, цуглаануудад ажиллаж байна.


Хүснэгт 16. Зөвшөөрөлтэй сүм хийдийн үндсэн ажиллагчдын тоо, шашны төрлөөр

Байршил	Ажиллагч- дын тоо, бүгд	Шашны төрлөөр					
		Будда	Христ	Ислам	Бөө мөргөл	Католик	Бусад (бахай, мүүн, шинто, хиндү)
Багануур	23	20	3				
Баянгол	815	675	122		16	2	
Баянзүрх	450	153	269		7	9	12
Налайх	26	17	6	3			
Сонгинохайрхан	174	97	67	6	2	2	
Сүхбаатар	221	133	61		6	2	19
Хан-Уул	47	15	15			17	
Чингэлтэй	165	109	56				
Нийслэлийн дүн	1921	1219	599	9	31	32	31

Зураг 12. Эмэгтэй ажиллагчид, шашны төрлөөр

Сүм хийдийн үндсэн ажилчдын бүрэлдэхүүнд 536 эмэгтэй ажиллаж байгаа нь нийт ажиллагчдын 27.9 хувийг эзэлж байв. Эмэгтэй үндсэн ажилчдын талаас илүү буюу 53.2 хувь нь христийн шашны сүм, цуглаануудад ажилладаг байна.

Бурханы шашны хийд, дацангийн үндсэн ажиллагчдын 16.2 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг байхад бөөгийн шашны ажиллагчдын 51.6 хувь, бусад шашны байгууллагад ажиллагчдын 64.5 хувийг эмэгтэй ажиллагсад эзэлж байна.



❖ **Шашны байгууллагын сайн дурын ажиллагчид**

Үндсэн ажиллагчдын сацуу нийслэлийн сүм хийд, шашны байгууллагуудад бүртгэлтэй сайн дурын 4577 ажилтан байна. Сайн дурынхан гол төлөв христийн сүм, цуглаануудад ажиллаж, сайн дурын нийт ажиллагчдын дүнд эзлэх хувийн жин өндөр (89.9%) гарав. Баянзүрх дүүрэгт байршилтай, христ морман урсгалын Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн үйл ажиллагаанд сайн дурын 3000 орчим ажилтан дэмжлэг үзүүлж, ажилладаг тул тус дүүрэгт хамгийн өндөр дүн гарахад нөлөөлсөн.

Хүснэгт 17. Зөвшөөрөлтэй сүм хийдийн сайн дурын ажиллагчид, шашны төрлөөр


Байршил	Сайн дурын ажиллагчдын тоо, бүгд	Шашны төрлөөр					
		Будда	Христ	Ислам	Бөө мөргөл	Католик	Бусад (бахай, мүүн, шинто, хиндү)
Багануур	25	-	25				
Баянгол	148	44	64		40	-	
Баянзүрх	3953	28	3698		207	2	18
Налайх	18	14	4	-			
Сонгинохайрхан	126	-	111	15	-	-	
Сүхбаатар	137	15	113		-	2	7
Хан-Уул	121	48	69			4	
Чингэлтэй	49	18	31				
Нийслэлийн дүн	4577	167	4115	15	247	8	25

Мөн түүнчлэн Баянзүрх дүүрэгт байршилтай, нийслэлийн 9 дүүрэг, 19 аймагт Бөөгийн хүрээлэн, сумдад төлөөллөө ажиллуулдаг, 200 орчим сайн дурын ажилтантай, Монголын бөөгийн нэгдсэн эвлэл сайн дурын ажилтнуудын дэмжлэг, туслалцаатайгаар үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг байна.

Зөвшөөрөлтэй нийт сүм хийдийн хэмжээнд 2990 сайн дурын эмэгтэй ажилтан ажилладаг байна. Эдгээрийн дийлэнх олонх буюу 93.0 хувь нь христийн шашны байгууллагуудад ногдож байв.

Бөөгийн шашны байгууллагуудад 117 эмэгтэй сайн дурын ажилтнаар харъяалагдаж байхад бурханы шашны байгууллагууд сайн дурын 57 эмэгтэй ажилтантай ажээ.

Зураг 13. Сайн дурын эмэгтэй ажиллагчид, шашны төрлөөр



❖ **Гадаадын ажиллагчид**

Энэ удаагийн тооллогын асуулгад нийслэлийн сүм хийд, шашны байгууллагад ажиллаж буй гадаадын иргэдийн талаарх мэдээллийг тусгаж өгсөн. Ингэхдээ Монгол Улсад зорчих гадаадын иргэдэд виз олгох, гадаадын иргэдийг Монгол Улсын хилээр нэвтэрснээс эхлэн буцаж гарах хүртэл хяналт тавих чиг үүрэг хүлээдэг Монгол Улсын Иргэний Харъяалал, Шилжилт Хөдөлгөөний Ерөнхий газрын холбогдох албадын ажилтнуудтай санал солилцож, хамтарч ажиллав.

Тооллогын ажилтнуудын сургалтад тус газрын Зөвшөөрөл, бүртгэлийн газрын мэргэжилтнийг урьж оролцуулан гадаадын иргэдийн бичиг баримттай хэрхэн танилцах, гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг ямар хэлбэрээр олгодог, тэр дундаа шашны шугамаар ирсэн гадаадын иргэдийн визний төрөл, оршин суух үнэмлэхний ангиллыг зөв таньж мэдэх талаар нэмэлт мэдээлэл хийлгэж, заавар зөвлөгөө, мэргэжлийн туслалцаа авч ажиллав.



Үүний үр дүнд тооллогын товын үеэр сүм хийд, шашны байгууллагын тэргүүнээр ажилладаг гадаадын иргэд, тооллогын ажилтан нарын хороонд ямар нэгэн үл ойлголцол, зөрчил маргаантай асуудал гараагүй болно.

Иргэний Харъяалал, Шилжилт Хөдөлгөөний Ерөнхий газрын Зөвшөөрөл, бүртгэлийн газрын зөвлөмжийн дагуу гадаадын иргэдийн нэрийг тооллогын асуулгад латин үсгээр бичиж, төрсөн он, сар, өдрийн хамт бүртгэж авсан.


Зураг 14. Гадаадын ажиллагчид, шашны төрлөөр

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй сүм хийд, шашны байгууллагад гадаадын 38 иргэн ажиллаж байна.

Гадаадын иргэдийг, ажиллаж байгаа шашны байгууллагынх нь төрлөөр ангилж үзвэл будда, христ, католик гэсэн гурван төрлийн шашны байгууллагад ногдож байв.

Гадаадын ажиллагчдын 71.1 хувь нь христийн шашны сүм, цуглаанд ажилладаг байна.

Сүм хийд, шашны байгууллагын үндсэн ажилтны бүрэлдэхүүнд бүртгэлтэй гадаадын дээрх ажиллагчдаас гадна мөн гадаадын 39 иргэн сайн дурын ажилтнаар ажиллаж байна. Сайн дурын гадаад ажилтнуудын 29 нь христийн шашны сүмд, долоо нь бурханы шашны байгууллагуудад, хоёр нь католик сүмд харъяалагдаж, нэг нь "шинто" шашинд ажилладаг байна.



Хүснэгт 18. Тэргүүнээр нь гадаадын иргэн ажилладаг сүм хийд, шашны төрлөөр

Байршил	Зөвшөөрөлтэй сүм хийдийн тоо	Үүнээс: Тэргүүнээр нь гадаадын иргэн ажилладаг сүм хийд	Шашны төрлөөр		
			Будда	Христ	Католик
Багануур	4	-			
Баянгол	50	6		5	1
Баянзүрх	81	7		6	1
Налайх	5	-			
Сонгинохайрхан	49	2		1	1
Сүхбаатар	41	1		1	
Хан-Уул	22	6	3	2	1
Чингэлтэй	31	3	3		
Нийслэлийн дүн	283	25	6	15	4

Албан ёсны зөвшөөрөлтэй нийт сүм хийдийн 8.8 хувь буюу 25 сүм хийд, шашны байгууллагын тэргүүнээр гадаадын иргэд ажиллаж байна. Гадаадын эдгээр иргэдийн 15 нь христийн шашны сүм, цуглааны тэргүүнээр ажилладаг байна.

Зураг 15. Шашны байгууллагын гадаадын иргэн тэргүүн нарын тоо, улс орноор



Сүм хийд, шашны байгууллагын тэргүүнээр ажиллаж байгаа гадаадын иргэдийг улс орноор нь ангилж харуулбал, 56.0 хувийг нь Өмнөд Солонгос Улсын иргэд эзэлж байна. Ази тивийн бусад улс орнуудаас Япон, Филиппин Улсын иргэн тус бүр хоёр, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны тусгай муж Хонг Конгийн харъяат иргэн нэг байв.

Мөн Америкийн Нэгдсэн Улсын иргэн хоёр, Канад, Бразил Улсын иргэн тус бүр нэг нэг байлаа. Харин Русская Православная церковь буюу Үнэн алдартны шашны Троицкийн сүм нь Оросын Холбооны Улсын өмчийн байранд үйл ажиллагаа явуулдаг хэдий ч сүмийн тэргүүнээр (священник) Беларусь Улсын иргэн ажилладаг байна.

ЗУРГАА. СҮМ ХИЙД, ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН ДЭМЖИГЧ, ИТГЭГЧИД

1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн хүрээнд хүний эрх, эрх чөлөө баталгаажсаны дотор шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө мөн нээлттэй болсон. Иргэн хүн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэх боломж бүрдэж төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулж өгсөн явдал нь ардчиллын томоохон ололтуудын нэг байв.

Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хуульд “Аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна”³ гэж заасан.

Монгол Улсын хэмжээнд хүн амын шашин шүтлэгийн талаарх мэдээлэл анх удаа 2010 оны улсын тооллогын үр дүнд бүрдсэн. Уг асуудал манай улсад зохион байгуулагдсан өмнөх тооллогуудын асуулгад огт тусгагдаж байгаагүй юм. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод “Та шашин шүтдэг үү, шүтдэг бол ямар шашин шүтдэг вэ?” гэсэн асуултыг “арван тав, түүнээс дээш насны хүн ам”-аас асуусан байдаг.

Тус тооллогын дүнгээр нийслэлийн арван тав, түүнээс дээш насны хүний тоо 871.9 мянгад хүрсэн бөгөөд 38.6 хувь нь ямар нэгэн шашингүйчүүд, 61.4 хувь нь буюу 535.4 мянган хүн шашин шүтэж байгаагийн 86.5 хувь нь буддын шашинтан байв.

Хүснэгт 19. Хүн амын шашин шүтлэгийн байдал, шашны төрөл, насны бүлгээр, 2010 он

	15, түүнээс дээш насны	Шашин шүтдэг	Үүнээс: Шашны төрлөөр					Дүнд эзлэх хувь	Шашин шүтдэггүй	
			Будда	Христ	Ислам	Бөө	Бусад			
15, түүнээс дээш насны хүн ам - Бүгд	871860	535397	463009	26535	5901	36436	3516	61.4	336463	
Насны бүлэг	15-19	121019	63756	52315	4447	1256	5347	391	52.7	57263
	20-24	159643	92023	76242	5408	1819	7879	675	57.6	67620
	25-29	116322	70245	59886	3391	662	5775	531	60.4	46077
	30-34	97609	60100	52641	2383	512	4161	403	61.6	37509
	35-39	86563	54611	47913	2491	398	3473	336	63.1	31952
	40-44	74127	47258	41318	2199	330	3089	322	63.8	26869
	45-49	67613	43770	38277	2149	302	2765	277	64.7	23843
	50-54	52379	35102	31198	1604	218	1865	217	67.0	17277
	55-59	31323	21402	19274	952	120	926	130	68.3	9921
	60-64	22676	16127	14868	592	89	490	88	71.1	6549
	65-69	16605	11876	11035	408	78	302	53	71.5	4729
	70+	25981	19127	18042	511	117	364	93	73.6	6854

Хүн амын нас ахих тутам тухайн насны нийт хүн амд шашин шүтдэг хүн амын эзлэх хувь нэмэгдэж байжээ. Тухайлбал, 15-19 насны хүүхэд залуучуудын 52.7 хувь шашин шүтдэг байхад 35-39 насныхны 63.1 хувь, 45-49 насны хүн амын 64.7 хувь, 55-59 насныхны 68.3 хувь, 70-аас дээш насны хүн амын 73.6 хувь нь шашин шүтдэг байв.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор нийслэлийн 26.5 мянган иргэн христийн шашинтан байсан нь арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 3.0 хувийг эзэлж байв. Шашин шүтдэг хүн амын дотор эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс илүү олон байдаг байна. Шашин шүтдэг нийт эмэгтэйчүүдийн 5.6 хувь буюу 16.7 мянган эмэгтэй христийн шашинтан байжээ.

³ Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл. IV боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 541.

Христийн болон бусад шашин шүтэх явдал 1990-ээд оноос өмнө үндсэндээ байгаагүй бол өнөөгийн монголчуудын оюун санааны амьдралд гадны шашны урсгал, чиглэл нэвтрэх болсон.

2014 онд анх удаа зохион байгуулсан сүм хийдийн тооллогын асуулгад тухайн шашны үзэл санаа, үйл ажиллагааг идэвхтэй дэмжигч, итгэгчдийн талаарх мэдээллийг тусгаж оруулсан бөгөөд христ, католик, бахай, мүүн, шинто, хиндү зэрэг уламжлалт бус шашны байгууллагууд зөвхөн Монгол Улсын иргэн, итгэгчдийнхээ тоог мэдээлэхээр тогтсон. Гэхдээ энд шашны төрлийн хувьд бурханы шашны байгууллагад хамаардаг Дотоку Кайкан, Монголын "Рисшо Косей-Кай" нийгэмлэг, исламын шашны Өмермечет сүм дэмжигч, итгэгчдийнхээ тоог мэдээлсэн байв.

Хүснэгт 20. Сүм хийдийн үйл ажиллагааг дэмжигчид болон итгэгчид, шашны төрлөөр

	Бүгд	Шашны төрлөөр				
		Христ	Католик	Бусад (бахай, мүүн, шинто, хиндү)	Будда	Ислам
Нийт дэмжигчид, бүгд	33626	31198	746	1337	300	45
Эмэгтэй	21243	19764	510	689	260	20
Бүгдээс: 16 хүртэлх насны хүүхэд	5573	5357	106	60	50	-
Эмэгтэй	3483	3337	69	37	40	-

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй албан ёсны зөвшөөрөл бүхий сүм хийд, шашны байгууллагуудын бүртгэлээр тэдний үйл ажиллагаа, үзэл санааг идэвхтэй дэмжигч, итгэгчдийн тоо 33.6 мянгад хүрсэн байна.

Итгэгчдийн үнэмлэхүй олонх нь христийн шашны байгууллагад ногдож, нийт дэмжигч, итгэгчдийн 93.8 хувийг эзэлжээ. "Бусад" шашны байгууллагуудын дотор зонхилох байр суурийг бахайн шашинд итгэгчид эзэлж, бахай шүтлэгтэй иргэдийн тоо 1.2 мянга орчим болсон байна. Түүнчлэн нийслэлийн 700 гаруй иргэд католик шашны итгэгчид байна. Шашны байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, сүсэг бишрэл, итгэл үнэмшлээ даган шашны итгэгч болсон насанд хүрэгчдийн 63.2 хувь нь эмэгтэйчүүд байв.

Түүнчлэн 16 хүртэлх насны 5.6 мянган хүүхэд шашны итгэгчид болж, оюун санааны боловсрол эзэмшиж байгаа нь шашны байгууллагын нийт дэмжигч, итгэгчдийн 16.6 хувьтай тэнцэж байв. Шашинд итгэгч хүүхдүүдийн 62.5 хувь нь 16 хүртэлх насны охид байна.

ДОЛОО. ШАШНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРӨЛ, УРСГАЛ**❖ Буддын шашин (Buddhism)**

Монголчууд бидний зонхилон шүтдэг шашин нь Түвдийн буддизмын шарын шашин (шар малгайтны ёс) бөгөөд бурханы шашны их хөлгөний ёсонд багтдаг. Дотроо шарын ёсны "гэлүгпа", улааны ёсны "нямава", "гармава", "сажава" гэсэн дөрвөн урсгалтай. Буддын шашны гол хоёр уламжлал болох их, бага хөлгөнүүд өөр өөрийн шүтлэгийн зан үйл болоод ариун судартай болон хөгжжээ.

Хүснэгт 21. Буддын хийд, дацан, шашны байгууллагын тоо, шашны урсгалаар

Байршил	Буддын сүм хийдийн тоо, бүгд	Үүнээс: Зөвшөөрөл авсан	Шарын	Улааны			
			гэлүгпа	нямава	гармава	сажава	бусад
Багануур	3	2	2				
Баянгол	24	23	12	7			4
Баянзүрх	19	17	9	4		1	3
Налайх	3	2	1	1			
Сонгинохайрхан	19	17	12	5			
Сүхбаатар	10	10	5	2			3
Хан-Уул	13	10	6	1			3
Чингэлтэй	15	13	7	4			2
Нийслэлийн дүн	106	94	54	24	-	1	15

Бурханы шашны байгууллагуудын 88.7 хувь нь албан ёсны зөвшөөрөлтэй байна. Буддын хийд, дацангууд гол төлөв Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт төвлөрч байв. Зөвшөөрөл авсан 94 хийд, дацангийн 54 нь бурханы шашны их хөлгөний ёсонд багтдаг шарын ёсны "гэлүгпа" урсгалыг баримталдаг байна.

Мөн улааны "нямава" ёсны чиг баримтлалтай 24 хийдийг тоолов. Уг шашны томоохон төлөөллийн нэг болох Улааны ёсны Тарвалин хийдийн Хамба лам Т.Ариунболд манай тооллогын ажилтнаар дамжуулан бид бүгдэд танин мэдүүлэх үүднээс тодорхой тайлбар хэлж өгсөнд нэн талархууштай. Тэрээр, улааны ёсны урсгалыг нямава бус "нинмава" гэдэг болохыг зориуд бичиж тэмдэглүүлсэн байгааг судалж, цаашид хэллэг дуудлагыг засч залруулах, зөв нэршлийн дагуу хэрэглэж хэвших нь зүйтэй байна.

Улааны шашны гармава ёсны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан хийд нийслэлийн хэмжээнд байхгүй байв. Гэхдээ Баянгол дүүрэгт зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан нэг хийдийг тоолсон.

"Сажийн ёс"-ны урсгал баримталдаг "Сажа бандидын номын хүрдэн хийд" Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байна. Тус хийдийн тэргүүний тайлбарлаж өгснөөр Сажа гэдэг нь Монголын Их хаадын үеийн шашин аж. Буддизмын сажийн ёсны тус урсгал нэрт аялагч, эрдэмтэн Догми (992-1072)-ийн сургаалийг дагадаг. Энэ ёс гүн ухаан, хэл шинжлэлийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулжээ.

Бурханы шашны дээрх урсгалуудын аль нэгэнд хамааруулах боломжгүй, гол төлөв холбогдох мэдээлэл нь дутуу, НИТХ-ын Ажлын албаны архив, Нийслэлийн Архивын газрын сан хөмрөг зэрэг бусад эх үүсвэрээс хайлт хийж, шүүгээд мэдээллийг бүрэн бүрдүүлж чадаагүй учраас шашны урсгалыг "бусад" гэдэгт оруулсан.

❖ **Бөө мөргөл** (*Shaman*)

Бөө хүн удам дамжин, мөн өөрөө өөрийгөө тодруулах замаар төрдөг. Бөөгийн шашинг эрт үед зөвхөн Арктик ба Төв Азийн ард түмэнтэй холбон авч үздэг байсан бол өнөө үед дэлхий даяар уг нэр томъёогоор төстэй шашин юмуу шашин маягийн тогтолцоог нэрлэх болсон. Манай орны хувьд “Тэнгэр шүтлэгт бөө мөргөл” хэмээн үзэж, Монголчуудын язгуурын шашинд тооцох үзэл нэлээд түгээмэл бий.

Тооллогын товын үеэр үйл ажиллагаа явуулж байсан бөөгийн шашны 22 байгууллагыг тоолов. Эдгээрийн 21 нь үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй байв.

Бөө мөргөлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг шашны ихэнх байгууллагууд нийслэлийн Баянгол, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байршиж байна.

Тооллогын дүнгээс харахад бөө мөргөлийн зан үйл, шашны үйлчилгээ үзүүлэх чиглэлээр зөвшөөрөл авсан байгууллага Багануур, Налайх дүүргээс гадна нийслэлийн төвийн Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт огт байхгүй ажээ.

Зураг 16. Бөөгийн шашны тоо, дүүргээр

❖ **Ислам шашин** (*Muslim*)

Исламын шашинтнуудын нийтээрээ цугларч мөргөл үйлддэг сүмийг Мечет (mosque) гэж нэрлэдэг. Мөн сүмд минарет буюу тагттай цамхаг, хатиб буюу номлогч бий. Суннит (Sunnite) урсгал нь исламын шашны үндсэн хоёр урсгалын томоохон нь бөгөөд дэлхийн исламын шашинтнуудын 90 хувийг бүрдүүлдэг. Исламын шашинтнууд Мекка дэхь Каба шүтээний зүг харсан кибла хана руу буюу наран жаргах зүг рүү хандан мөргөх ёстой аж.

Манай орны казах иргэдийн хувьд уламжлалт шашин шүтлэг нь исламийн шашин бөгөөд 1990 оны 10 сард Монголын мусульманы нийгэмлэг байгуулагдаж, 1992 онд болсон хурлаараа нийгэмлэгийнхээ нэрийг өөрчлөн “Монголын ислам шашны төв” хэмээн нэрлэж байжээ.

Сүм хийдийн 2014 оны тооллогоор исламын шашны үйл ажиллагаа явуулдаг 4 сүмийг тоолов. Эдгээрийн 2 нь албан ёсны зөвшөөрөлтэй бөгөөд нийслэлийн Налайх, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байршин ажиллаж байна.

Үлдэж буй хоёр сүм нь нийслэлийн Баянгол, Налайх дүүрэгт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байв. Үүний нэг нь “Ел бирлиги” төрийн бус байгууллагын салбараар Налайх дүүрэгт ажиллаж байна. Тус төрийн бус байгууллага нь казах үндэсний хэл, соёл, шашин, зан заншлын үнэт зүйлийг хадгалах, түгээн дэлгэрүүлэх, түүнтэй уялдсан хүмүүнлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байна. Тус байгууллагын өөр нэг салбараар Сонгинохайрхан дүүрэгт байрлах, исламын шашны Өмөрмечет сүм ажилладаг байна. Төрийн бус байгууллагын дор нэгдсэн эдгээр салбарууд нь шашны үйл ажиллагаанаас гадна соёлын төвийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг ажээ. Тухайлбал, Толгойт бүсэд 2010 онд баригдаж, нээлтээ хийсэн “Исламын соёлын төв”, 2012 оноос Налайх дүүрэгт “Коняа соёлын төв” тус тус үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.



❖ Христийн шашин (*Christianity*)

Есүсийн сургаалд үндэслэн МЭ I зуунд үүссэн шашин. Ариун судар нь Библи, тэр дундаа Шинэ гэрээ. Христийн шашин нь дэлхийн бараг бүх улс оронд шүтэн бишрэгчидтэй, олон урсгал чиглэлтэй, түүхэн хөгжлийн явцад хамгийн их хувьсан өөрчлөгдсөн шашин юм.

Христийн шашны 228 сүм, цуглаан нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байв. Эдгээрийн 67.5 хувь буюу 154 сүм шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй байна. Христийн шашны байгууллагууд нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хамгийн олноор төвлөрчээ. Зөвшөөрөл авсан христийн шашны байгууллагуудын 36.4 хувийг тус дүүрэгт байрлах сүм, цуглаанууд эзэлж байгаа юм.

Мөн түүнчлэн зөвшөөрөл авсан христийн шашны нийт сүм, цуглааны 18.2 хувь нь Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байршин үйл ажиллагаа явуулж байна. Бусад дүүрэгтэй харьцуулахад зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй сүм, цуглааны тоо хэмжээ Сонгинохайрхан дүүрэгт хамгийн олон байв.

Хүснэгт 22. Христийн сүм, цуглааны тоо, шашны урсгалаар

Байршил	Христийн сүмийн тоо, бүгд	Үүнээс: Зөвшөөрөл авсан	Шашны урсгалаар											
			Протестант	Евангэл	Баптист	Методист	Просвитериян	Пентикост	Адвентист	Еховагийн гэрч	Үнэн Алдартан	Морман	Пропетриан	Бусад
Багануур	8	2		2										
Баянгол	23	17	3	3	3		2	3	1	1				1
Баянзүрх	65	56	24	15	3	4	5	1			1	1	1	1
Налайх	11	2	1											1
Сонгинохайрхан	49	28	19	4	3	1	1							
Сүхбаатар	24	21	9	4	3	2		3						
Хан-Уул	23	10	7					2						1
Чингэлтэй	25	18	4	4	2	4	1		1					2
Нийслэлийн дүн	228	154	67	32	14	11	9	9	2	1	1	1	1	6

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй христийн шашны байгууллагууд нь дотроо ялгамжтай өөр өөр урсгал, чиглэлийг төлөөлж байдгаараа онцлог юм. Тухайлбал, протестант урсгалыг баримтлагч сүмүүд зонхилж, албан ёсны зөвшөөрөлтэй христийн шашны 43.5 хувийг эзэлж байна.

НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөл авсан христийн шашны протестант урсгалын төлөөлөл нийслэлийн Багануур дүүргээс бусад бүх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс гадна протестант шашны 28 байгууллага нийслэлд зөвшөөрөлгүй ажиллаж байв.

- Протестант шашин (*Protestantism*) нь христийн шашны гурван том салбарын нэг. Энэ нэр томъёог католик болон үнэн алдартны шашныг баримталдаггүй христийн шашинтнуудын итгэл үнэмшлийг нэрлэхдээ хэрэглэдэг.

Евангелист чиг баримталдаг 32 сүм байгаагийн 46.9 хувь нь Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байршиж байна. Зөвшөөрөл авсан христийн евангелист сүм нийслэлийн Налайх, Хан-Уул дүүрэгт байхгүй боловч энэ хоёр дүүргийн хэмжээнд нийтдээ таван сүм зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байв. Тухайлбал, тооллогын товын үеэр бүртгэгдсэн христ евангелийн нийт сүмийн 39.6 хувь нь буюу 21 сүм албан ёсны зөвшөөрөлгүй байв.

- Евангелист шашин (*Evangelicalism*) Библийг сүсэг бишрэлийн цорын ганц үндэс хэмээн үзэж амьдрал, гэр бүлийн хүрээнд баримталдаг протестант шашны хөдөлгөөн. XVIII зууны үед Европ, Америкт өрнөсөн шашны сэргэлтийг ерөнхийд нь евангелийн сэргэлт гэж нэрлэдэг.

Баптист урсгалтай христийн 14 сүм, цуглаан нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тооны харьцаа төвийн таван дүүрэгт жигд байв. Христийн шашны байгууллагуудын дүнд баптист урсгалтай сүмүүдийн эзлэх хувийн жин 9.1 байна.

- Баптист (*Baptist*) Зөвхөн насанд хүрсэн итгэгчдийг усанд булхуулж загалмайлх ёстой гэж үздэг бүлэг христийн протестант шашинтнуудын гишүүн. Баптист итгэл үнэмшил нь сүсэг бишрэл, ажил хэргийн асуудал дээр орон нутгийн цуглаануудын эрх мэдлийг чухалчилдаг бөгөөд мөргөл хийхдээ урьдаас бэлдээгүй залбирал хэлж, магтаал дуу дуулахын зэрэгцээ номлолдоо Библиэс иш татдаг.

Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт христийн методист урсгалтай 11 сүм, цуглаан үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс гадна Налайх, Баянзүрх дүүрэгт зөвшөөрөлгүй нэг нэг сүм ажиллаж байв.

- Методизм (*Methodism*) XVIII зууны Англид Жон Вэсли-ийн үүсгэсэн протестант шашны хөдөлгөөн. Методизм нь анх Английн сүмийг шинэтгэх хөдөлгөөн болж эхэлсэн, 1795 он хүртэл албан ёсоор сүмээс харилцаагаа таслаагүй. Аж үйлдвэрийн салбарын ажилчин ангийн дунд онцгойлон амжилттай байсан тус хөдөлгөөн нь XIX зуунд хурдан хугацаанд цар хүрээгээ тэлсэн. Методист сургаал Ариун сүнсний хүч, хүн өөрөө Бурхантай холбоотой байх хэрэгтэй, мөргөлийн энгийн байдал, ядуу хоосон амьдралыг чухалчилдаг.

Эдгээрээс гадны просвитериан болон пентикост урсгалыг төлөөлдөг сүм хийд тус бүр 5.8 хувьтай байгаа бол адвентист урсгалтай хоёр сүм, Еховагийн гэрчүүд, пропетриан, үнэн алдартан, христ морманы чиглэл тус бүр нэг ажиллаж байна. Түүнчлэн огт өөр урсгал баримталдаг 6 сүм, цуглаан байв. Тухайлбал, шашны урсгалаа "крисматик", "карисматик" гэж их ойролцоо дуудлагатай боловч хоёр өөр янзаар бүртгүүлсэн сүмтэй нийслэлийн Налайх, Баянгол дүүрэгт таарч байв.

Христийн шашны урсгалууд нь өөр хоорондоо нийгэм, улс төрийн чиг баримжаа, сургаал номлолын тайлбарлал ба эх сурвалжаараа, тахил шүтээний ёс, заншил уламжлалаараа ялгагдах бөгөөд эл ялгаа нь өчүүхэн төдий үл ялгах байдалтай байхаас эхлээд бүр эрс тэс, харилцан үгүйсгэх хүртэл янз бүрийн хэмжээ хүрээтэй байх нь ажиглагддаг.




❖ **Католик шашин** (*Roman Catholicism*)

Нэг тэрбум гаруй сүсэгтэнтэй христийн шашны хамгийн том салбар. Католик шашин нь Өрнөдийн соёл иргэншилд гүн нөлөө үзүүлсэн бөгөөд дэлхийн өнцөг булан бүрт христийн шашин дэлгэрэхэд их үүрэг гүйцэтгэсэн. Сүм нь хатуу чанд шатлан захирах зохион байгуулалттай. Ромын пап кардиналуудыг томилж, захирдаг бөгөөд кардиналуудын тоо XX зууны сүүлээр огцом өсч II Иоан Паул (1978-2005) папын үед 182 хүрчээ. Зөвхөн эрчүүд санваартан болдог ч ариун гэр бүлд багтахыг хүссэн эмэгтэйчүүд гэлэнмаагийн сахил хүртэж гэлэнмаа нарын бүлэг болон гэлэнмаагийн хийдэд хамрагддаг.

Олныг хамарсан мөргөлийн үндсэн хэлбэр нь евхаристын ариун ёслол юм. Хэдийгээр маргаантай асуудал олонтаа тулгарсан ч тус шашин гурав дахь мянганы босгон дээр дэлхийн хамгийн том басхүү нөлөө бүхий шашны байгууллага хэвээр байна.*

* *Britannica ширээний нэвтэрхий толь, 3, 1512 дахь тал*



Бахай шүтлэг бол бүх хүн ардуудыг нэгэн нэгдмэл Үйл хэрэг, нэгэн түгээмэл Шүтлэгт нэгтгэх зорилготой даян дэлхийн бие даасан шашин юм. Бахай гэдэг нь Бахауллагийн дагалдагч гэсэн утгатай. Учир нь Бахаулла XIX зууны дундуур Иранд үүсгэсэн.

1863 онд Бахаулла өөрийгөө Баб урьдчилан зөгнөсөн, Аллахын илгээсэн элч хэмээн зарласнаар бабизмаас тусгаарласан. Тэрээр 1892 онд нас барахаасаа өмнө өөрийн хүү Абдул-Бахаг хүй хамтлагийнхаа тэргүүнээр зарлажээ. Бахайн шашинтнууд бүх шашин дотоод мөн чанараараа адил бөгөөд хүн төрөлхтөн ч нэгдмэл гэж тунхагладаг. Тэд нийгмийн ёс суртахуунд анхаарал хандуулдаг бөгөөд хувраг санваартан болон шашны ямар нэг нууц зан үйлгүй.

Анх энэ сургаалыг 19 хүн дагасан болохоор энэ тоог ариун гэж үздэг ба тус бүр 19 хоногтой, (нэмэлт дөрвөн өдөр) 19 сартай хуанлитай. Сүсэгтнүүд нь өдөр бүр мөргөл үйлдэх ба жилд 19 хоног зан суртлын хатуу дүрэм бүхий сахил сахидаг. 1960-аад оноос бахайн шашинд орогсод илт нэмэгдсэн боловч 1979 онд хуучинсаг үзэлтнүүд хувьсгал хийснээс хойш Иранд тэднийг мөрдөж мөшгих болсон.

Үзэл санаа, сургаал номлолын агуулга, үйлдэл шүтлэгийнхээ шинжээр өмнө дурдсан дэлхий дахины шашнуудын аль нэг төрөлд хамрагддаггүй цаг хугацааны хувьд тэднээс эрс хожуу үүссэн шашны урсгалуудыг шинэ шашинд хамруулдаг. Эдгээрийн нэг нь бахайн шашин юм. “Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулган” нэртэйгээр анх 1998 онд үүсгэн байгуулагдсан. Нийслэлд шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй.

❖ **Шинто шашин** (*Shinto*)



Японы уугуул шашин. Ками хэмээх сүнсийг тахин шүтэхэд үндэслэгдсэн. Шинто (“Ками-д хүрэх зам”) хэмээх нэр томъёо нь Японы уугуул итгэл үнэмшлийг Японд VI зуунд нэвтэрсэн буддизм-аас ялгахын тулд хэрэглэгдэх болсон. Камигийн нууц далдын бүтээгч болон зохицуулагч хүчинд итгэх нь Шинтогийн гол цөм юм.

Нийслэлд “шинто” шашны хоёр байгууллага үйл ажиллагаа явуулдаг төдийгүй хоёул албан ёсны зөвшөөрөлтэй, мөн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байршдаг байна.

❖ **Хиндү шашин** (*Hinduism*)



Дэлхийн голлох шашнуудын эртнийх нь. Эртний Энэтхэгийн Ведийн шашнаас дэлгэрсэн. Брахман гэгдэх орчлонгийн туйлын үнэний зарчим болон бодгалын сүнс буюу Атман-ы бодит байдалд итгэх нь хиндү шашны суурь ойлголт юм. XXI зууны эхэн үед дэлхий даяар 850 сая гаруй хиндү шашинтан байна.

Нийслэлд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй шашны байгууллагуудын отгон төлөөлөл нь хиндү шашин юм. Баянзүрх дүүрэгт “Кришна Мандир” нэрээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус байгууллагад НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 9 дүгээр сарын 153 тоот тогтоолоор шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгожээ.

Ийнхүү баримталдаг чиглэл, номлол сургаалийн талаас нь авч үзэхэд 7 төрлийн шашинд хамаарах 20 шахам урсгал чиглэлийг төлөөлсөн уламжлалт бус шашны байгууллагууд нийслэлд байршин үйл ажиллагаа явуулж байна.

НАЙМ. ЗӨВШӨӨРӨЛГҮЙ СҮМ ХИЙД

Тооллогын товын үеэр шашны үйл ажиллагаа явуулж байсан 372 сүм хийдийн 23.9 хувь нь буюу 89 сүм хийд зөвшөөрөлгүй байв. Ихэвчлэн христийн шашны сүм, цуглаанууд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж, 83.1 хувийг эзэлж байв.

Хүснэгт 23. Зөвшөөрөлгүй сүм хийдийн тоо, шашны төрлөөр

Байршил	Сүм хийдийн тоо, бүгд	Үүнээс: Зөвшөөрөлгүй сүм хийд	Шашны төрлөөр					
			Будда	Христ	Ислам	Бөө мөргөл	Католик	Бусад (бахай, мүүн, шинто, хиндү)
Багануур	11	7	1	6				
Баянгол	59	9	1	6	1	1		
Баянзүрх	92	11	2	9				
Налайх	16	11	1	9	1			
Сонгинохайрхан	72	23	2	21				
Сүхбаатар	44	3		3				
Хан-Уул	38	16	3	13				
Чингэлтэй	40	9	2	7				
Нийслэлийн дүн	372	89	12	74	2	1	-	-

Бурханы шашны байгууллагуудын тухайд Сүхбаатар дүүргээс бусад дүүрэгт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдол гарав. Энэ нь тоо хэмжээний хувьд дүүрэг бүрт ойролцоо байна.

НИТХ-ын Тэргүүлэгчдээс гаргасан журмыг зөрчиж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа христийн сүмүүдийн 28.4 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 17.6 хувь нь Хан-Уул дүүрэгт байна. Өөрөөр хэлбэл, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа шашны сүм, цуглаануудын тал шахам хувь нь тус хоёр дүүргийн нутаг дэвсгэрт, гол төлөв гэр хороололд байршиж байна.

Мөн исламын шашны хоёр сүм нийслэлийн Баянгол, Налайх дүүрэгт байршин үйл ажиллагаа явуулж байгааг тоолов. Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт бөө мөргөлийн чиглэлээр нэг байгууллага зөвшөөрөлгүй ажиллаж байгааг мөн бүртгэв.

Харин католик болон бусад шашны төлөөллөөс зөвшөөрөлгүй ажиллаж байгаа тохиолдол гараагүй болно.

ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

2014 онд анх удаа хийгдсэн сүм хийд, шашны байгууллагын тооллогыг зохих журам, удирдамжийн дагуу явуулснаар дараах үр дүнд хүрэв. Тухайлбал:

- Тооллогод Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан болон зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа нийт сүм хийдийг хамруулж, тоолов. Түүнчлэн төрийн бус байгууллагын нэрийн дор шашны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд, шашны бусад зан үйлийн үйлчилгээ үзүүлдэг зурхайч, мэргэ төлөгч, бөө зэрэг зарим хувь хүмүүсийг холбогдох мэдээллийн хамт, дүүрэг бүрээр бүртгэв.
- Сүм хийд, шашны байгууллагын тооллогын товын үеэр нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 372 сүм хийд, шашны байгууллага байгааг тоолж, бүртгэв. Тоологдсон нийт сүм хийдийн 76.0 хувь буюу 283 сүм хийд нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй байна.
- Бурханы шашин нь Монгол оронд хэдэн зууны турш байж, ард түмний амьдрал хэвшилд шингэсэн шашин. Нийслэлийн иргэдийн шүтэх бишрэх эрхийг хангахад зонхилох байр суурийг бурханы шашны байгууллагууд гүйцэтгэсэн хэвээр байна.
- Бурханы шашны байгууллагуудын 88.7 хувь нь албан ёсны зөвшөөрөлтэй байна. Буддын хийд, дацангууд гол төлөв Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт төвлөрч байв. Зөвшөөрөл авсан 94 хийд, дацангийн 54 нь бурханы шашны их хөлгөний ёсонд багтдаг шарын ёсны “гэлугпа” урсгалыг баримталдаг байна.
- Монголын бурхан шашинтны төв гэдэг утгаараа Гандан хийд, Монголын нийт лам нарын цогчин дуганыг барьж байгаагийн сацуу дэргэдээ шашны дунд, их сургууль, жүд дацангийн сургууль, уламжлалт анагаах ухааны болон гүн ухааны сургууль, 120 хүүхдийн цэцэрлэг, асрамжийн газар ажиллуулдаг байна.
- Хэдийгээр бөөгийн онгод буулгадаг хувь хүмүүс хот, хөдөөд олширсон боловч бөө мөргөлийн зан үйлийн үйлчилгээг шашны байгууллагын зохион байгуулалт дор нэгтгэж, сүсэгтэн олонд хүргэж үйлчлэх албан ёсны зөвшөөрөл авсан байгууллага нийслэлд харьцангуй цөөн байна.
- Тооллогын товын үеэр үйл ажиллагаа явуулж байсан бөөгийн шашны 22 байгууллага байв. Эдгээрийн 21 нь үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөл авсан байна. Чингэлтэй, Хан-Уул дүүргээс бусад нийслэлийн төвийн зарим дүүрэгт, 4-5 төрлийн шашны төлөөлөл үйл ажиллагаа явуулж байхад бөө мөргөлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан шашны байгууллага Багануур, Налайх дүүрэгт төдийгүй нийслэлийн төвийн Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт нэг ч байхгүй байв.
- Уламжлалт шашны байгууллагуудын зэрэгцээ 6-7 төрлийн шашинд хамаарах 20 шахам урсгал чиглэлийг төлөөлсөн уламжлалт бус шашны байгууллагууд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй бөгөөд тэдгээрийн дотор “христийн шашны сүм, цуглааны” эзлэх хувийн жин харьцангуй давамгайлж, талаас илүү буюу 54.4 хувийг эзэлж байна.
- Зөвшөөрөлтэй сүм хийдийн дүнд хамгийн бага хувийн жин эзэлж буй шашны төрөлд бөө мөргөл, католик, исламын шашин багтаж байгаагийн зэрэгцээ бахай шүтлэг, мүүнийн шашин мөн сүүлийн жилүүдэд Монголын нийгэмд нэвтэрч эхлээд удаагүй байгаа шинто, хиндү шашны байгууллагууд орж байна.
- Энэ удаагийн тооллогоор Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хамгийн олон буюу 92 сүм хийд тоологдсоны 88.0 хувь нь зөвшөөрөлтэй байв.

- Тоологдсон гурван сүм тутмын хоёр нь нийслэлийн гэр хороололд төвлөрч байна. Ялангуяа Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт сүм хийдийн 80 шахам хувийг “гэр хороололд” байршилтай сүм хийд эзэлж байна.
- Сүм хийд, шашны байгууллагууд өмнө авсан зөвшөөрлийн хугацааг хоёр хэлбэрээр хэтрүүлдэг байна. Үүний эхний хэлбэрт, шашны үйл ажиллагаа эрхлэхээр зөвшөөрөл анх авсан хугацаанаас хойш “сунгалт огт хийлгээгүй” байх зөрчил орж байв. Ийм байдлаар зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн сүм хийд нийслэлийн хэмжээнд 58 байна.
- Зөвшөөрлийн хугацааг хэтрүүлж буй хоёр дахь хэлбэрт “сунгалтын хугацааг хэтрүүлэх” явдал хамаарч байгаа юм. Тухайлбал, тооллогын товын үеэр, зөвшөөрөлтэй нийт сүм хийдийн 51.6 хувийг өмнө олгогдсон зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг хэтрүүлсэн сүм хийд эзэлж байв.
- Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа эрхлэн явуулахаар зөвшөөрөл авсан сүм хийд, шашны байгууллагуудын 74.6 хувь нь санхүүгийн тайлан тэнцэл гаргаж, 25.4 хувь нь “тайлан тэнцэл огт гаргадаггүй” байна. Санхүүгийн тайлан тэнцэл гаргадаггүй гэж мэдээлсэн сүм хийдийн 37.5 хувь нь хэвийн үйл ажиллагаатай байв.
- Зөвшөөрөлтэй нийт сүм хийдээс 25 сүм хийд, шашны байгууллагын тэргүүнээр гадаадын иргэд ажиллаж байна. Гадаадын эдгээр иргэдийн 60 хувь нь христийн шашны сүм, цуглаанд ажиллаж, Өмнөд Солонгос Улсын иргэд 56.0 хувийг эзэлж байна.
- Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй албан ёсны зөвшөөрөл бүхий уламжлалт бус шашны байгууллагуудын бүртгэлээр тэдний үйл ажиллагаа, үзэл санааг идэвхтэй дэмжигч, итгэгчдийн тоо 33.6 мянгад хүрсэн байна. Эдгээр иргэдийн 63.2 хувь нь эмэгтэйчүүд, 5.6 мянга нь 16 хүртэлх насны хүүхдүүд байна. Шашинд итгэгч хүүхдүүдийн 62.5 хувь нь 16 хүртэлх насны охид байна.
- Нийслэлийн сүм хийд, шашны байгууллагыг бүртгэлжүүлэх зорилготой уг тооллогод GPS төхөөрөмж ашигласнаар сүм хийд нэг бүрийн байршлыг тогтоож, өгөгдөлтэй мэдээллийг боловсруулан Google map дээр байршуулж, орон зайн мэдээллийн санг анх удаагаа бүрдүүлж байгаагаараа ихээхэн онцлог юм.
- Нийслэлийн сүм хийдийн тооллогод хамрагдсан сүм хийд, шашны байгууллага нэг бүрт тооллогод хамрагдсан болохыг илтгэх, тодорхой өгөгдөл, нууцлал бүхий “гэрчилгээ” олгосон явдал сүм хийдийн зүгээс тооллогын ажилд хандах байдалд сайнаар нөлөөлж, идэвх, оролцоог нэмэгдүүлэв.
- Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шашны байгууллагын байршил, шашны төрөл, урсгал, лам санваартан, үндсэн ажиллагсад, гадаадын болон сайн дурын ажилтнууд, шашны үйл ажиллагааг дэмжигч насанд хүрсэн иргэд төдийгүй насанд хүрээгүй хүүхэд, итгэгчдийн тоо мэдээлэл зэрэг бусад олон чухал үзүүлэлтээр анхан шатны бүртгэлийг цаашид байнга шинэчлэн хөтөлж, хянан зохицуулах нөхцөл бүрдэв.
- Анхан шатны бүртгэл болон тооллогын мэдээллээр нийслэлийн түвшинд байгуулсан мэдээллийн санд тогтмол давтамжийн дагуу баяжилт хийх боломж бүрдсэнээр сүм хийдэд олгогдсон зөвшөөрлийн хугацаанд тавих хяналтын механизм сайжирч, хугацаа тулгах, хэтрүүлэх зэрэг гарч болох зөрчлүүдээс урьдчилан сэргийлж, шаардлагатай мэдээллийг холбогдох сүм хийд нэг бүрт хүргэх, өөр хоорондоо төдийгүй чиг үүргийн хамаарал бүхий төрийн төв болон нутгийн захиргааны бусад байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, мэргэжил арга зүйн туслалцаа авах боломж нээгдэж байна.
- Мэдээллийн сан нь сүм хийд, шашны мэдээллийн талаарх найдвартай эх үүсвэр бий болгох, шашны байгууллагын үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагын хяналтыг нэмэгдүүлэх, хоорондын үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлогыг тодорхойлж, боловсруулахад бодитой мэдээлэл болж чадах юм.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

- Шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэж байгаа нь илэрхий тодорхой нөхцөлд улсын бүртгэлийн гэрчилгээнд шашны үйл ажиллагааг заавал тусгаж, тодотгож өгөх шаардлагатай байна. Учир нь зарим сүм хийд, шашны байгууллагууд аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрийн хувьд төрийн бус байгууллагаар бүртгэгддэг тул шашны үйл ажиллагааг төрийн бус байгууллагын нэрийн дор эрхлэх явдал нэлээд байна.
- Шашны байгууллагуудын өмнө авсан зөвшөөрлийн хугацааг дахин сунгасан тухай Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гарах бүрт нэн ялангуяа гадаадын иргэд ажилладаг сүм хийдийн хугацааг сунгасан тохиолдолд Монгол Улсын Иргэний Харьяалал, Шилжилт Хөдөлгөөний Ерөнхий газрын Зөвшөөрөл, бүртгэлийн газарт хүргүүлж байх талаар зохих анхаарал хандуулах ажил хэргийн зайлшгүй шаардлага байна.
- Албан ёсны зөвшөөрөлтэй 50 шахам сүм хийдийн үйл ажиллагаа жигд, тогтвортой явагдаж чадалгүй зогсонги байдалд орсон байна. Ийнхүү нэгэнт үйл ажиллагаагаа хэвийн түвшинд явуулж чадахгүйд хүрсэн сүм хийдийн асуудлыг хянан зохицуулах, холбогдох арга хэмжээ авах шаардлага тавигдаж байна.
- Нийслэлийн Статистикийн Газраас эрхлэн захиргааны статистик мэдээг бүрдүүлэх чиглэлээр олон тооны тооллого, судалгааг явуулж байна. Тооллого, судалгааны мэдээллээр нийслэлийн түвшинд байгуулсан мэдээллийн сангийн ашиглалт хангалтгүй төдийгүй тогтмол давтамжийн дагуу баяжилт огт хийхгүй, үйл ажиллагаа нь зөвхөн Нийслэлийн Статистикийн Газрын оролцоотой сайжирдаг муу жишээ нийслэлийн нутгийн захиргааны асуудал хариуцсан байгууллагуудад байна.

Иймд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллага, түүний ажлын алба бусдад үлгэр жишээч байдал үзүүлэн сүм хийд нэг бүрийн байршлыг тогтоож, шашны байгууллагуудын талаарх чухал шаардлагатай мэдээллийн хамт бүрдүүлсэн тооллогын мэдээллийн сан болон орон зайн мэдээллийн сангийн ашиглалтыг нэмэгдүүлж, цаашид сүм хийд шинээр бүртгэх, зөвшөөрлийн хугацааг сунгах, шашны байгууллагуудын хаяг байршилд орсон өөрчлөлтийг бүртгэх зэрэг бусад баяжилтыг цаг тухайд нь хийж ажиллахыг зөвлөж байна.

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР

Хавсралт 1. Шивэлт хийх хэсэг

Сүм хийдийн бүртгэлийг оруулах

А. Хаягийн хэсэг

№	Дугаар:	
1.	Дүүргийн нэр:	16. Сонгинохайрхан
2.	Хороо дугаар:	
3.	Гудамж, хорооллын нэр:	
4.	Байшингийн дугаар:	
5.	Хашаа, хаалганы дугаар:	

Б. Ерөнхий мэдээлэл

1.	Сүм хийд, шашны байгууллагын тэргүүний нэр:	
	Регистрийн дугаар: (Гадаад иргэдийн төрсөн он сар өдөр)	
2.	Аль улсын харьяат вэ?	0. Монгол
3.	Үүрэн утасны дугаар:	
	Суурин утасны дугаар:	
4.	Сүм хийд, шашны байгууллагын нэр:	
	Байгууллагын регистрийн дугаар:	
5.	Үйл ажиллагааны чиглэл:	9491. Шашны байгууллагын үйл ажиллагаа
6.	Шашны төрөл:	1. Будда
7.	Шашны урсгал:	101. Гэлүгпа
8.	Байгуулгын үүрэн утасны дугаар:	
	Байгуулгын суурин утасны дугаар:	
9.	Вэб хуудасны нэр:	
	И-мэйл:	


В. Үндсэн мэдээлэл

1.	Сүм хийдийн байршил/дугаар:	2. Гэр хороолол
	GPS	
2.	Үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй эсэх?	1. Тийм
3.	Хэрэв "тийм" бол зөвшөөрөл шинээр олгосон НИТХ-ын тогтоолын огноо, дугаар:	
4.	Үйл ажиллагааны хугацааг сунгасан НИТХ-ын хамгийн сүүлийн тогтоолын огноо, дугаар	
5.	Үйл ажиллагаа явуулж буй ажлын байрны эзэмшлийн хэлбэр:	1. Өөрийн эзэмшлийн
6.	Танай байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна уу?	1. Тийм
7.	Үйл ажиллагаагаа хэвийн явуулаагүй шалтгаан:	1. Үйл ажиллагаа эхлээгүй
	Үйл ажиллагаагаа зогсоосон огноо:	
8.	Танай байгууллага үйл ажиллагаагаа жилийн турш явуулдаг уу?	1. Жилийн турш
9.	Танайх салбар сүм хийд болон шашны байгууллагатай юу?	2. Үгүй
10.	Хэрэв "тийм" бол салбар сүм хийд болон шашны байгууллагын тоог бичнэ үү!	
11.	Танай байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ:	3. Улаанбаатар хотын хэмжээнд
12.	Жил, улирлын тайлан тэнцэл гаргадаг эсэх?	1. Тийм
13.	Санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг ажилтан:	2. Гэрээт нягтлан
14.	Статистикийн албан ёсны мэдээ, тайланг тогтмол гаргаж өгдөг эсэх?	1. Тогтмол
15A.	Танай байгууллагын бүх ажиллагчдын тоо	
	Эмэгтэй ажиллагчдын тоо	
	Гадаад ажиллагчдын тоо	
15B.	Сайн дурын бүх ажиллагчдын тоо	
	Сайн дурын эмэгтэй ажиллагчдын тоо	
	Сайн дурын гадаад ажиллагчдын тоо	
16A.	Танай шашны үзэл санаа, үйл ажиллагааг идэвхтэй дэмжигч, сүсэгтнүүдийн тоо:	
	Үүнээс эмэгтэй:	
16B.	16 хүртэлх насны бүх хүүхэд	
	Үүнээс эмэгтэй:	

Тайлбар

Хадгалах

Нийслэлийн Статистикийн газар



Нийслэлийн Статистикийн газар

Хавсралт 5. Үр дүнгийн хүснэгт

Удирдах хэсэг	Сүм хийдийн тайлан									
» Маягт шивэх	Тайлангийн төрөл: 7. Албан ёсны зөвшөөрөлтэй сүм хийдийн тоо, шашны төрлөөр									
» Алдаа шалгах	Дүүрэг: -Бүгд-									
» Газрын зурагт харах	Харах									
» Тайлан										
Хэрэглэгчийн хэсэг										
» Нүүр хуудас										
» Хэрэглэгчийн тохиргоо										
» Гарах										
Шивсэн төлөв байдал										
Нийт: 372										
Алдаатай: 0										
				Шашны төрлөөр						
				Будда	Христ	Ислам	Бөө	Католик	Бусад	
Багануур	11	4	2	2	0	0	0	0	0	
Багахангай	0	0	0	0	0	0	0	0	0	
Баянгол	59	50	23	17	0	9	1	0	0	
Баянзүрх	92	81	17	56	0	4	2	2	2	
Налайх	16	5	2	2	1	0	0	0	0	
Сонгинохайрхан	72	49	17	28	1	2	1	0	0	
Сүхбаатар	44	41	10	21	0	6	1	3	3	
Хан-Уул	38	22	10	10	0	0	2	0	0	
Чингэлтэй	40	31	13	18	0	0	0	0	0	
Нийслэлийн дүн	372	283	94	154	2	21	7	5	5	

Нийслэлийн Статистикийн газар

Удирдах хэсэг	Сүм хийдийн тайлан							
» Маягт шивэх	Тайлангийн төрөл: 2. Сүм хийд, байршлаар, ажлын байрны эзэмшлээр							
» Алдаа шалгах	Дүүрэг: -Бүгд-							
» Газрын зурагт харах	Харах							
» Тайлан								
Хэрэглэгчийн хэсэг								
» Нүүр хуудас								
» Хэрэглэгчийн тохиргоо								
» Гарах								
Шивсэн төлөв байдал								
Нийт: 372								
Алдаатай: 0								
		Байршлаар			Ажлын байрны эзэмшлийн хэлбэрээр			
		Байшин хороололд	Гэр Хороололд	Холимог	Өөрийн эзэмшлийн	Түрээсийн	Бусад	
Багануур	11	4	7	0	8	2	1	
Багахангай	0	0	0	0	0	0	0	
Баянгол	59	29	25	5	33	12	14	
Баянзүрх	92	32	59	1	46	27	19	
Налайх	16	0	16	0	12	1	3	
Сонгинохайрхан	72	14	57	1	51	6	15	
Сүхбаатар	44	23	20	1	17	8	19	
Хан-Уул	38	8	30	0	23	5	10	
Чингэлтэй	40	15	25	0	26	7	7	
Нийслэлийн дүн	372	125	239	8	216	68	88	